

**ХУУЛЬ, ХҮЧНИЙ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИД БОЛОН
ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТНУУДАД ХОЛБОГДОХ
ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ ХАРААТ БУС БАЙГУУЛЛАГЫН
ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА: МОНГОЛ УЛС БОЛОН
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D), Г.Билгээ, Д.Жигваагүнсэл
О.Нарантуяа, Р.Нургул, Р.Оргилмаа
Р.Өнөрсайхан, Ц.Элбэгзаяа*

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

НЭГ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

- 1.1 Бүгд Найрамдах Армен улс: Мөрдөн шалгах тусгай албаны тухай
Бүгд Найрамдах Армен Улсын хууль (албан бус орчуулга)
- 1.2 Оросын Холбооны Улс
- 1.3 Монтенегро Улс
- 1.4 Бүгд Найрамдах Солонгос Улс
- 1.5 Америкийн Нэгдсэн Улс
- 1.6 Украин Улс

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ТУРШЛАГА

- 2.1 Монгол Улсын мөрдөн байцаах албаны үүсэл, хөгжил түүний
өөрчлөлт, шинэчлэл

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгааны захиалгын дагуу хууль, хүчний байгууллагын албан хаагчидтай холбоотой гэмт хэргийн шинжтэй мэдээллийг шалгах хараат бус, бие даасан байгууллага, тэдгээрийн чиг үүрэг, эрх хэмжээ, харьяаллын талаарх бусад орнуудын туршлагыг харьцуулан судлав. Судалгаанд БНАУ, ОХУ, БНСУ, АНУ, Украин, Монтенегро зэрэг улсуудыг хамруулснаас гадна Монгол Улсын туршлагыг тоймлон оруулав.

Монгол Улсын тухайд: Улсын Ерөнхий Прокурорын газрын дэргэдэх **Мөрдөн байцаах алба нь** УИХ-ын 2002 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 47 дугаар тогтоолоор байгуулагдан ажиллаж байгаад 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Прокурорын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан мөн өдрийн УИХ-ын 22 дугаар тогтоолоор татан буугдаж, харьяалал нь Авлигатай тэмцэх газарт шилжжээ.

Одоо **Авлигатай тэмцэх газарт хэрэг бүртгэх, мөрдөн байцаах чиг үүрэг бүхий Мөрдөн шалгах хэлтэс** ажилладаг бөгөөд тус хэлтэс нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар харьяалуулсан, Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргүүдийг мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг.

Мөн түүнчлэн Цагдаагийн Ерөнхий газрын харьяанд Мөрдөн байцаах алба ажиллаж байна. Уг албаны **Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтэс нь** Улсын ерөнхий прокурорын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/67 дугаар тушаалаар Улсын ерөнхий прокурорын газраас шалгах харьяалал тогтоосон шүүгч, прокурор, Авлигатай тэмцэх газрын алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг.⁹³

Бусад орнуудын тухайд: Энэхүү судалгаанд Армэн, Орос, Монтенегро, Өмнөд Солонгос, Америк, Украин зэрэг улсуудын хувьд ижил чиг үүрэг бүхий мөрдөх албадын туршлагыг судалсан бөгөөд тэдгээрийн харьяалал, чиг үүрэг, эрх хэмжээ, эрх зүйн орчин болон бусад холбогдох туршлагын талаарх мэдээллийг оруулсан болно. Судалгаанд хамруулан орнуудаас Бүгд Найрамдах Армэн Улсын Мөрдөн шалгах тусгай албаны үйл ажиллагааг бие даасан хуулиар тусгайлан зохицуулсан байх тул захиалагчид цэгцтэй мэдээлэл өгөх үүднээс уг хуулийг бүрэн эхээр нь орчуулан хүргүүлж байна. (Албан бус орчуулга хавсаргав).

Дээрх орнуудыг засаглалын хувьд авч үзвэл ихэнх нь буюу Армэн, Өмнөд Солонгос, Орос, Америк зэрэг улсууд ерөнхийлөгчийн засаглалтай, Монтенегро улс парламентын засаглалтай, Украин улс холимог засаглалтай байна.

⁹³<http://police.gov.mn/a/3456>

Мөрдөх албаны тухайд авч үзвэл дээрх улс орнуудад ижил чиг үүрэгтэй албад байх боловч харьяалал, нэршил нь улс орон бүрт өөр өөр байна. Тухайлбал:

- Армен Улсад Мөрдөн шалгах тусгай алба нь **Засгийн газрын харьяанд;**
- ОХУ-д Мөрдөн байцаах хороо нь **ОХУ-ын Ерөнхийлөгчийн удирдлага дор;**
- Монтенегрод Улсын тусгай прокурорын алба нь **Прокурорын газрын дэргэд;**
- АНУ-д Мөрдөн шалгах алба нь **Хууль зүйн яамны харьяанд;**
- Украинд Улсын мөрдөн байцаах газар нь **Засгийн газрын дэргэд** ажилладаг байна.

Дээрх орнуудын Мөрдөх албадын эрх зүйн зохицуулалтыг авч үзвэл ихэнх нь тусгайлсан хуулиар үйл ажиллагаагаа зохицуулж байна. Тухайлбал:

- Армен Улсын Мөрдөн шалгах тусгай албаны үйл ажиллагааг **Мөрдөн шалгах тусгай албаны тухай хууль** (Закон о специальной следственной службе) болон Үндсэн хууль, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх процессийн тухай хууль, Иргэний хууль, Мөрдөн байцаах тусгай албаны ажлын албаны журам, олон улсын гэрээ хэлэлцээр, холбогдох бусад хууль тогтоомжуудаар;
- ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны үйл ажиллагааг **Мөрдөн байцаах хорооны тухай хууль** (Закон О Следственном комитете РФ) болон Үндсэн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, Эрүүгийн хууль, “ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны тухай” ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, “ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны үйл ажиллагааны тухай” ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг зэрэг хууль тогтоомжуудаар;
- Монтенегро улсын хувьд Улсын тусгай прокурорын албаны үйл ажиллагааг **Монтенегро Улсын тусгай прокурорын албаны тухай хууль** (law on special public prosecutor's office of Montenegro) болон Улсын прокурорын үйлчилгээний тухай хуулиар;
- Украины Улсын мөрдөн байцаах газрын үйл ажиллагааг **Улсын мөрдөн байцаах газрын тухай хууль** (The Law of Ukraine “On the State Bureau of Investigation”), Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудаар тус тус зохицуулна.
- АНУ-ын хувьд Хууль зүйн яамнаас баталсан Холбооны улсын эрх зүйн актуудын код (Code of Federal regulations)-ын 28 дугаар хэсгийн VI бүлгийн 600 (28 CFR Part 600)-д **Тусгай төлөөлөгчид холбогдох** асуудлуудыг тус тус зохицуулсан байна.

Судалгааны үр дүнг нэгтгэн, бусад улс орнуудын мөрдөх албадын туршлагыг тоймлон авч үзвэл:

АРМЕН УЛС:

Армен Улсын Мөрдөн шалгах тусгай алба нь 2007 онд батлагдсан **Мөрдөн шалгах тусгай албаны тухай хуулиар** (Закон о специальной следственной службе) байгуулагдсан бөгөөд хараат бус байдлаар бүрэн эрхээ хэрэгжүүлдэг

бие даасан статустай байгууллага байна. Энэ хуулиар Мөрдөн шалгах тусгай алба байгуулах болон үйл ажиллагаа явуулах нөхцөл, журам, мөн албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой харилцаа, албан тушаалын ангилал, зэрэглэл, эрх, үүрэг хариуцлага, эрх зүйн, болон нийгмийн баталгаа, албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой бусад харилцааг зохицуулна.

Бүтцийн хувьд Мөрдөн шалгах тусгай алба нь дараах хэлтсүүдээс бүрдэнэ.⁹⁴ Үүнд:

- Авлига, зохион байгуулалттай гэмт хэрэг, албан тушаалтны гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтэс (*Department of Investigation of Corruption, Organized and Official Crimes*);
- Эрүүдэн шүүх болон хүний эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтэс (*Department of Investigation of Tortures and Crimes against Person*);
- Нийтлэг шинжтэй гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтэс (*Department of Investigation of Crimes of General Character*) зэрэг болно.

Мөрдөн шалгах тусгай алба нь Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх процессийн тухай хуульд заасны дагуу хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын удирдах албан тушаалтан болон төрийн тусгай албаны ажилтан албан тушаалаа урвуулан ашиглах, эсхүл биеэр үйлдсэн гэмт хэрэг, мөн сонгуулийн үйл явцтай холбоотой эрүүгийн гэмт хэргийг урьдчилан мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулна.⁹⁵

Дээрх хуульд зааснаар хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын удирдах ажилтанд дараах албан тушаалтныг хамруулна.⁹⁶

Үүнд:

- Улсын Ерөнхийлөгч;
- Ерөнхий сайд,
- Шадар сайд;
- Парламентын гишүүд;
- Үндсэн хуулийн цэцийн тэргүүн болон гишүүд;
- Шүүхийн тэргүүн болон шүүгчид;
- Улсын Ерөнхийлөгчийн ажлын албаны дарга;
- Үндэсний Хурлын (парламент) ажлын албаны дарга;
- Засгийн газрын ажлын албаны дарга;
- Засгийн газрын сайдууд, дэд сайдууд;
- Засгийн газрын харьяа агентлагууд болон төрийн захиргааны төв байгууллагын дарга, орлогчид;
- Мужийн захирагч, тэдгээрийн орлогчид;
- Ереван хотын захирагч, түүний орлогчид;
- Армен Улсын Төрийн Хянан Шалгах Палатын зөвлөлийн дарга, гишүүд;
- Армен Улсын Төв банкны дарга, зөвлөлийн гишүүд;

⁹⁴<http://www.ccc.am/en/1428926241>

⁹⁵Мөрдөн байцаах тусгай албаны тухай хууль, 1 дүгээр бүлэг, 2.1 дүгээр зүйл
<http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=3124&lang=rus>

⁹⁶Мөрдөн байцаах тусгай албаны тухай хууль, 1 дүгээр бүлэг, 4.2 дугаар зүйл
<http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=3124&lang=rus>

- Армен Улсын зохицуулах хороодын дарга, гишүүд;
- Армен Улсын Сонгуулийн хорооны дарга, гишүүд;
- Армен Улсын Үндэсний Статистикийн хорооны дарга, орлогч дарга зэрэг болно.

Төрийн тусгай албаны ажилтанд дараах албан хаагчид орно.⁹⁷ Үүнд:

- Прокурор;
- Батлан хамгаалах салбар дахь төрөөс бүрэн эрх олгосон байгууллагад ажилладаг мөрдөгчид (следователи государственного уполномоченного органа в области обороны);
- Цагдаагийн албан хаагч (цэргийн цагдаа орохгүй);
- Үндэсний аюулгүй байдлын албан хаагч (хилийн цэрэг, зэвсэгт хүчин орохгүй);
- Татварын байгууллагын албан хаагч;
- Гаалийн байгууллагын албан хаагч;
- Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх байгууллагын албан хаагч;
- Эрүүгийн хэргийн гүйцэтгэх алба;
- Авран хамгаалах албаны албан хаагч зэрэг болно.

Энэхүү тусгай алба нь Бүгд Найрамдах Армен Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасан хүний болон иргэний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийг дээдлэн хүндэтгэх, хүнлэг энэрэнгүй, ил тод байх зарчмыг баримтлан ажилладаг.

Мөрдөн шалгах тусгай албаны даргыг Армен Улсын Ерөнхий прокурорын санал болгосноор Ерөнхийлөгч томилох бөгөөд хуульд заасан үндэслэлийн дагуу албан тушаалаас чөлөөлнө. Мөрдөн шалгах тусгай албаны дарга үйл ажиллагааны талаарх мэдээллийг Армен Улсын Үндэсний Их Хурал (парламент) болон Ерөнхийлөгчид жил бүр бичгээр тайлагнана.

Мөрдөн шалгах тусгай албанаас явуулж буй урьдчилан мөрдөн шалгах ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхэд Армен Улсын Ерөнхий прокурор болон түүнээс эрх олгосон тусгай прокурорууд хяналт тавина.

ОХУ:

ОХУ-д мөрдөн байцаах ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг бүхий ОХУ-ын Мөрдөн байцаах хороо (Следственный комитет РФ) ажилладаг.

2010 онд **ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны тухай хууль**⁹⁸ батлагдаж 2011 онд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Мөрдөн байцаах хорооны **удирдлагыг**

⁹⁷Мөрдөн байцаах тусгай албаны тухай хууль, 1 дүгээр бүлэг, 4.3 дугаар зүйл

<http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=3124&lang=rus>

⁹⁸ФЗ О Следственном комитете РФ от 28.12.2010 г. № 403-ФЗ.

ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны тухай хуулиар түүний үйл ажиллагааны зорилго, зарчим, бүтэц, зохион байгуулалт, түүний удирдлагын томилох, чөлөөлөх, албан хаагчдад тавигдах шаардлага, хязгаарлалт, хориг, тэдэнд олгох тусгай цол, цолны нэмэгдэл болон мөнгөн урамшууллын хэмжээ, шагнал урамшуулал, төрийн хамгаалалтад байх баталгаа, нийгмийн хангамж, заавал хамрагдах даатгалын төрөл, хүлээлгэх хариуцлага, албан үүргээс нь чөлөөлөх болон үйл ажиллагаанд нь тавих прокурорын хяналт зэрэг харилцааг зохицуулна.

ОХУ-ын Ерөнхийлөгч хэрэгжүүлэх бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 151.2-т зааснаар дараах 4 чиглэлээр эрүүгийн хэргийг мөрдөн байцаах ажиллагаа явуулна. Үүнд:

1. Үндсэн хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний эсрэг, хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг, нийтийн аюулгүй байдлын эсрэг, төрийн эрх мэдэл, төрийн алба, орон нутгийн байгууллагын ашиг сонирхлын эсрэг, захиргааны хариуцлагын эсрэг, шударга ёсны эсрэг, цэргийн албаны эсрэг гэх мэт эрүүгийн гэмт хэргүүд;
2. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 447 дугаар зүйлд заасан төрийн өндөр албан тушаалтнууд, тэдгээрийн албан тушаалын болон мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой эрүүгийн гэмт хэргүүд;
3. ОХУ-ын хууль, хүчний байгууллагын албан тушаалтнууд, тэдгээрийн албан тушаалын болон мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой эрүүгийн гэмт хэргүүд;
4. Насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн болон насанд хүрээгүй хүүхэдтэй холбоотой хүнд, онц хүнд гэмт хэргүүд орно.

Мөрдөн байцаах хорооны тухай хуулийн 13.2, 14.2, 15.6, МБХ-ны дүрмийн 16-д тус тус заасны дагуу ОХУ-ын Ерөнхийлөгч нь МБХ-ны даргын санал болгосноор МБХ-ны дарга, түүний 1-р орлогч, бусад орлогчдыг; ерөнхий болон ОХУ-ын субъектүүдийн мөрдөн байцаах газрын дарга, тэдгээрийн 1-р орлогчид, бусад орлогчдыг; бусад удирдах албан тушаалтнуудыг томилж, чөлөөлнө.

Хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу МБХ-ны дарга жил бүр ОХУ-ын Ерөнхийлөгчид ажлаа тайлагнана. Мөн хуулийн 44 дүгээр зүйлд МБХ-ны мөрдөн байцаах үйл ажиллагаанд ОХУ-ын Ерөнхий прокурор болон бусад прокурорууд хяналт тавихаар заасан байна.

МОНТЕНЕГРО УЛС:

Монтенегро Улсын Прокурорын газрын дэргэд мөрдөн байцаах чиг үүрэг бүхий **Улсын тусгай прокурорын алба** ажилладаг. Тус албаны үйл ажиллагааг 2015 оны 02 дугаар сарын 26-нд батлагдсан **“Монтенегро Улсын тусгай прокурорын албаны тухай хууль”⁹⁹ (law on special public prosecutor's office of Montenegro)**-аар зохицуулсан байна.

Энэхүү хууль нь Улсын тусгай прокурорын албаны бүтэц зохион байгуулалт, шүүх эрх мэдэл, Улсын тусгай прокурорын албаны дарга болон тусгай прокуроруудыг сонгох шаардлага ба процедур, бусад төрийн болон захиргааны албадуудтай хэрхэн харилцах хэм хэмжээ, албаны үйл ажиллагаанд холбогдох бусад харилцааг зохицуулна.

Улсын тусгай прокурорын алба нь дараах тасаг, албадаас бүрдэнэ.

- Санхүүгийн мөрдөн байцаах тасаг
- Дүн шинжилгээ, судалгааны тасаг
- Олон улсын хамтын ажиллагааны тасаг

⁹⁹[https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2015\)012-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2015)012-e)

Хуулийн 3-р зүйлд зааснаар Улсын Тусгай прокурорын алба нь дараах гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэнэ. Үүнд:

1. хуулиар заасан хугацаа харгалзахгүйгээр аливаа зохион байгуулалттай гэмт хэрэг;
2. өндөр түвшний (их хэмжээний) авлига:

а) хэрвээ төрийн албан тушаалтан¹⁰⁰ дараах гэмт хэргүүдийг үйлдсэн бол:

- албан тушаалаа урвуулан хэрэглэсэн;
- албан үүргээ гүйцэтгэх үедээ хууран мэхэлсэн;
- албан тушаалын нөлөөгөө худалдаалсан;
- албан тушаалын нөлөөгөө худалдаалах сэдэл төрүүлсэн;
- авлига өгсөн;
- авлига авсан.

б) хэрвээ дараах гэмт хэргийг үйлдээд 40.000 еврогоос давсан орлого олсон бол:

- үйл ажиллагаанд албан тушаалаа урвуулан ашигласан;
- эдийн засагт эрх мэдлээ урвуулан ашигласан.

3. мөнгө угаасан;
4. терроризм;
5. цэргийн гэмт хэрэг зэрэг болно.

Улсын тусгай прокурорын албаны үйл ажиллагааг Улсын прокурорын үйлчилгээний тухай хуулийн дагуу боловсруулсан Удирдлагын төлөвлөгөөнд үндэслэн Улсын дээд прокурорын алба хянана.

ӨМНӨД СОЛОНГОС УЛС:

Тус улс нь Авлигатай тэмцэх бие даасан байгууллагатай боловч Улсын Дээд прокурорын газрын бүтцэд авлигын эсрэг болон зохион байгуулалттай гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий тусгай хэлтэс ажилладаг. Тус хэлтэс нь Ерөнхий прокурорт шууд харьяалагдах бөгөөд босоо удирдлагын тогтолцоотой байна. Прокурорын мөрдөн байцаах ажиллагааг прокурорын цагдаа болон тусгай мөрдөн байцаах алба (*Special Investigation Agency*) явуулна.

Тусгай мөрдөн байцаах алба нь дүүргийн прокурорын газраас шилжүүлсэн хэрэг болон хууль тогтоомжоор өөрт харьяалуулсан гэмт хэргүүдэд тусгай мөрдөн шалгах, мөрдөн байцаах ажиллагаа явуулна. Үүнд:

- Авлигын 5 том гэмт хэрэг;
- Батлан хамгаалах үйл ажиллагаан дахь авлигын гэмт хэрэг;
- Үндэсний баялгийг гадагш гаргахтай холбоотой авлигын гэмт;
- Орон нутаг дахь авлига, хүний нөөцийн томилгоотой холбоотой авлига;
- Санхүүгийн болон үнэт цаастай холбоотой гэмт хэрэг зэрэг болно.

¹⁰⁰Энэхүү хуульд төрийн албан тушаалтан гэдгийг төрийн эрх мэдэлтэн, төрийн захиргааны эрх мэдэлтэн, нутгийн өөрөө удирдах эрх мэдэлтэн, нутгийн захиргааны эрх мэдэлтэн (цаашид албаны эрх мэдэлтэн гэнэ), бие даасан эрх мэдэлтэн, зохицуулах эрх мэдэлтэн, олон нийтийн байгууллага, олон нийтийн аж ахуйн нэгж, эсхүл аливаа бизнесийн байгууллага, эсхүл хуулийн этгээд зэрэг олон нийтийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч, эсхүл нийтийн ашиг сонирхлын төлөөх үйл ажиллагаа эрхэлдэг төрийн мэдлийн үйл ажиллагааг эрхлэгчид, сонгогдсон, нэр дэвшсэн, эсхүл томилогдсон хүнийг, эсхүл сонгогдсон, нэр дэвшсэн, томилогдсон албаны эрх мэдэлтэй хүнийг ойлгоно.

Солонгос Улсын хувьд Прокурорын байгууллага нь Хууль зүйн яам, Цагдаагийн байгууллага нь Дотоод хэргийн яаманд харьяалагддаг. Хууль хүчний байгууллагын ажилтнууд, төрийн өндөр албан тушаалтантай холбоотой гэмт хэргийг тусгайлан мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг байгууллагын талаарх мэдээлэл судалгааны явцад олдоогүй болно.

АНУ:

Америкт **хууль сахиулах байгууллагын албан хаагчидтай холбоотой гэмт хэргийг Хууль зүйн яам** (*Department of Justice*)¹⁰¹ мөрдөн шалгана.

Уг алба нь цагдаагийн албан хаагчид, засан хүмүүжүүлэх газрын ажилтнууд, шүүгч, прокурор болон холбооны улсын, мужийн, орон нутгийн хууль сахиулах байгууллагын албан хаагчдад холбогдох хүч хэрэглэсэн, эрх мэдэл, албан тушаалаа хэтрүүлэн ашигласан, хилсээр баривчилсан, шүүгдэж буй этгээдэд бие махбодын болон сэтгэл санааны хохирол учруулсан, санаатайгаар эмнэлгийн тусламж үзүүлэхээс зайлсхийсэн, бэлгийн дарамт үзүүлсэн, гэмт хэргийг таслан зогсоохоос зайлсхийсэн зэрэг гэмт хэргүүдийг мөрдөн шалгадаг. Түүнчлэн гэмт хэргийг илрүүлэх явцад саад хийсэн, хохирогч болон гэрчийг мэдүүлэг өгөхөд саад учруулсан, мэдүүлгийг хуурамчаар үйлдсэн, хэргийг нуун дарагдуулсан, баримт нотолгоог хуурамчаар үйлдсэн зэрэг хэргүүдийг мөрдөж ял оноодог.¹⁰²

Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд болон төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой гэмт хэргийн мэдээллийг Хууль зүйн сайд бөгөөд Ерөнхий прокурорын томилсон Тусгай төлөөлөгч (*Special Counsel*) шалгаж, мөрдлөг явуулдаг байна. АНУ-д Ерөнхий атторней буюу Ерөнхий прокурор нь нэгэн зэрэг Хууль зүйн асуудал хариуцсан сайдын алба хашдаг онцлогтой.¹⁰³

Холбооны улсын эрх зүйн актуудын код (*Code of Federal regulations*)-д заасны дагуу **Тусгай төлөөлөгч** нь өөрт олгосон эрхийн хүрээнд АНУ-ын аль ч прокурорын адил мөрдлөг явуулах, ял оноох эрхтэй. Мөн тухайн хэргийн мөрдөлт аль шатанд явж байгаа зэрэг хэрэгт холбоотой мэдээллийг Ерөнхий прокурор болон Хууль зүйн яамны ажилтнуудад мэдээлэх эсэхээ өөрөө шийдэх бүрэн эрхтэй байна.

Тусгай төлөөлөгч нь Хууль зүйн яамны дүрэм, журамд заасны дагуу мөрдлөгийн явцад бий болсон гэнэтийн үйл явдлын талаар Ерөнхий прокурорт мэдээлэх шаардлагатай. Мөрдөн шалгах үйл явц дууссаны дараа гэмт этгээдэд ногдуулсан ял, эсхүл гэм буруугүйг нотолсон нотолгоог Ерөнхий прокурорт танилцуулна. Тусгай төлөөлөгчийн мөрдсөн болон ял ногдуулсан аливаа хэргийг Хууль зүйн яамны дүрэм, журамд заасны дагуу Ерөнхий прокурор олон нийтэд мэдээлэх эсэхийг шийдвэрлэнэ.

¹⁰¹<https://www.justice.gov/crt/law-enforcement-misconduct>

¹⁰²<https://www.law.cornell.edu/uscode/text/18/242>

¹⁰³Б. Цэрэнбалтав, Б. Амарбаясгалан "Прокурорын хяналт", 2009, УБ

УКРАИН:

Украин Улсын Парламентаас 2015 оны 11 сарын 12-ны өдөр Улсын мөрдөн байцаах газрын тухай хууль¹⁰⁴-ийг баталж, 2016 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн байна.

Улсын мөрдөн байцаах газар нь 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

Улсын мөрдөн байцаах албаны тогтолцоо нь төв аппарат, нутаг дэвсгэрийн нэгж дэх салбар, тусгай нэгж, боловсрол, судалгааны байгууллагаас бүрдэнэ. Тус газар нь Төрийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан албан тушаал ерөнхийлөгч, парламентын гишүүд, засгийн газрын гишүүд, үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, сонгуулийн төв хорооны гишүүд, засгийн газрын гишүүд, төв банкны ерөнхийлөгч, шүүгч болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудын үйлдсэн гэмт хэрэг, мөн авлигатай тэмцэх газрын албан хаагчдын үйлдсэн Эрүүгийн хуулийн худал мэдүүлэг өгөх, худал мэдүүлэг өгүүлэхээр албадах, мөрдөн шалгах ажиллагааны нууц задруулах, гэмт хэргийг үл мэдээлэх зэрэг гэмт хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагааг явуулна.

Улсын мөрдөн байцаах газар нь Засгийн газрын дэргэдэх төв байгууллага бөгөөд тус байгууллагаас явуулах мөрдөн шалгах ажиллагаанд Прокурорын байгууллага хяналт тавьж ажилладаг.

УМБГ-ын даргыг Ерөнхий сайдын санал болгосноор Украин улсын Ерөнхийлөгч 5 жилийн хугацаагаар томилох ба улируулан томилохыг хориглоно.

Улсын мөрдөн байцаах албаны үйл ажиллагаа, зохион байгуулалтын бүтцийг мөрдөн байцаах албаны дарга нь Засгийн газартай зөвшилцөж батлахаар заасан байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

¹⁰⁴The Law of Ukraine "On the State Bureau of Investigation", <https://zakon3.rada.gov.ua/laws/show/794-19>

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ**НЭГ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ****1.1. БҮГД НАЙРАМДАХ АРМЕН УЛС**

Армен Улсад Засгийн газрын харьяа¹⁰⁵ Мөрдөн шалгах тусгай алба ажилладаг бөгөөд уг албаны үйл ажиллагааг 2007 онд батлагдсан Мөрдөн шалгах тусгай албаны тухай хуулиар (Закон о специальной следственной службе) зохицуулдаг. Армен Улс нь Ерөнхийлөгчийн засаглалтай боловч Монгол улстай төрийн байгууламжийн хувьд ижил нэгдмэл улсын статустай, хуучин социалист орон юм. Тус улсын Мөрдөн шалгах тусгай албаны тухай хууль нь харьцангуй нарийвчилсан зохицуулалттай, загвар болохуйц хууль байх тул бүрэн эхээр нь орчуулж хавсаргав.

Албан бус орчуулга

**МӨРДӨН ШАЛГАХ ТУСГАЙ АЛБАНЫ ТУХАЙ БҮГД
НАЙРАМДАХ АРМЕН УЛСЫН ХУУЛЬ¹⁰⁶**

Батлагдсан огноо: 28.11.2007

Нэгдүгээр бүлэг. Ерөнхий зүйл

Хоёрдугаар бүлэг. Мөрдөн шалгах тусгай албаны тогтолцоо, албан хаагчдыг томилох, чөлөөлөх, зэрэг цол олгох нөхцөл ба журам

Гуравдугаар бүлэг. Мөрдөн шалгах тусгай албаны алба хаагчдын эрх зүйн баталгаа, эрх, үүрэг болон албан үүргийн хэрэгжилтэнд хяналт тавих, аттестатчилах, давтан сургах

Дөрөвдүгээр бүлэг. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсдын материаллаг хангамж, нийгмийн болон бусад баталгаа

Тавдугаар бүлэг. Мөрдөн шалгах тусгай албаны ажлын аппарат, санхүүжилт

Зургадугаар бүлэг. Шилжилтийн нөхцөлүүд

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ****1-р зүйл. Хуулийн зохицуулалтын хамрах хүрээ**

Энэ хуулиар Мөрдөн шалгах тусгай алба байгуулах болон үйл ажиллагаа явуулах нөхцөл, журам, мөн албанд алба хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхтэй

¹⁰⁵Мөрдөн байцаах тусгай албаны ажлын албаны журам, 3 дугаар бүлэг 13 дугаар зүйл
<http://www.ccc.am/ru/1428578692>

¹⁰⁶Закон Республики Армения "О Специальной Следственной Службе"
<http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=3124&lang=rus>

холбоотой харилцаа, албан тушаалын ангилал, зэрэглэл, эрх, үүрэг хариуцлага, эрх зүйн болон нийгмийн баталгаа, албан үүрэгтэй нь холбоотой бусад харилцааг зохицуулна.

2-р зүйл. Мөрдөн шалгах тусгай алба

1. Мөрдөн шалгах тусгай алба нь Армен Улсын Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх процессийн тухай хуульд заасны дагуу хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын байгууллагуудын удирдах албан тушаалтнууд болон төрийн тусгай албаны ажилтнуудын хамжаа оролцоотойгоор үйлдэгдсэн эрүүгийн гэмт хэргүүд, эдгээр албан тушаалтнуудын биечлэн үйлдсэн эрүүгийн гэмт хэргүүд, мөн түүнчлэн бүх шатны сонгуулийн процесст үйлдэгдсэн эрүүгийн гэмт хэргүүдийг урьдчилан мөрдөн шалгана. Армен Улсын Ерөнхий прокурор дээрх албан тушаалтнуудад хамааралтай хэргийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд шаардлагатай гэж үзвэл хэргийг ердийн журмаар мөрдөн шалгаж байсан байцаагч мөрдөн байцаах байгууллагаас хэргийг татан авч Мөрдөн байцаах тусгай албанд шалгуулахаар шилжүүлж болно.
2. Мөрдөн шалгах тусгай алба нь төрийн онцгой үүрэгтэй албанд тооцогдох тул тус албанд ажиллагсдын эрх зүйн байдлыг энэхүү хуулиар тогтооно. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсад нь төрийн тусгай албан хаагчийн статустай байна.
3. Мөрдөн шалгах тусгай алба нь Армен Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх процессийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн хүнлэг, энэрэнгүй, ил тод, хүний эрх, эрх чөлөө, нэр хүндийг дээдэлж, хуулийн зарчимд нийцүүлэн үйл ажиллагаа явуулна.
4. Мөрдөн шалгах тусгай албанаас явуулж буй урьдчилан мөрдөн шалгах ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхэд Армен Улсын Ерөнхий прокурор болон түүнээс эрх олгосон тусгай прокурорууд хяналт тавина.
5. Мөрдөн шалгах тусгай албыг Албаны дарга удирдана.
6. Мөрдөн шалгах тусгай алба нь үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг ил тод болгох ба тусгай албаны дарга нь Армен Улсын Үндэсний Их Хурал болон Ерөнхийлөгчид үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг жил бүр бичгээр тайлагнана.
7. Мөрдөн шалгах тусгай албаны төв оффис Ереванд байрлана.

3-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны талаарх хууль тогтоомж

1. Мөрдөн шалгах тусгай албаны тухай хууль тогтоомж нь энэ хууль, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх процессийн тухай хууль, Армен Улсын холбогдох бусад хууль тогтоомж болон олон улсын гэрээ хэлэлцээрүүдээс бүрдэнэ.
2. Хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд Мөрдөн шалгах тусгай албаны дарга дотоод үйл ажиллагааны журам тогтоосон эрх зүйн акт болон бие даасан шийдвэр гаргана.

3. Хэрэв энэ хуульд заасан асуудлыг Армен Улсын нэгдэн орсон гэрээ хэлэлцээрт өөрөөр заасан бол олон улсын гэрээ хэлэлцээрийн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

4-р зүйл. Хуульд заасан нэр томьёо, үндсэн ойлголтууд

Энэ хуульд дараах нэр томьёо, ойлголтуудыг ашиглана.

1. Мөрдөн шалгах тусгай албаны ажилтан - гэж тус албаны дарга, түүний орлогч, онц ноцтой гэмт хэргийг мөрдөн шалгах ахлах мөрдөн байцаагчид болон онц ноцтой гэмт хэргийн мөрдөгчдийг хэлнэ.
2. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын байгууллагуудын удирдах албан тушаалтнууд - гэж Армен Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Шадар сайд, Үндэсний Их Хурлын гишүүд, Үндсэн хуулийн цэцийн гишүүд, Шүүх байгууллагын дарга нар болон шүүгчид, Армен Улсын Ерөнхийлөгчийн ажлын албаны дарга, Армен Улсын Үндэсний Их Хурлын ажлын албаны дарга, Армен Улсын Засгийн газрын ажлын албаны дарга, Засгийн газрын сайдууд болон дэд сайдууд, Засгийн газрын харьяа агентлагууд болон төрийн захиргааны төв байгууллагын дарга, орлогчид, Мужийн захирагч, тэдгээрийн орлогчид, Ереван хотын захирагч, түүний орлогчид, Армен Улсын Төрийн Хянан Шалгах Палатын зөвлөлийн дарга, гишүүд, Арменийн Төв банкны дарга, зөвлөлийн гишүүд, Армен Улсын зохицуулах хороодын дарга ба гишүүд, Армен Улсын Сонгуулийн хорооны дарга, гишүүд, Армен Улсын Үндэсний Статистикийн хорооны дарга, орлогч дарга нарыг хэлнэ.
3. Төрийн тусгай албанд үүрэг гүйцэтгэгч - гэж батлан хамгаалах салбар дахь төрөөс бүрэн эрх олгосон байгууллагад ажилладаг мөрдөгчид, прокурорууд, цагдаагийн алба (зэвсэгт хүчний цагдаад хамаарахгүй), үндэсний аюулгүй байдлын алба (хилийн цэрэг, зэвсэгт хүчний салбар ангиуд хамаарахгүй), татвар, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, эрүүгийн хэргийн гүйцэтгэх алба, авран хамгаалах алба зэрэг тусгай албадын эрх бүхий албан тушаалтнуудыг хэлнэ.
4. Сонгуулийн процесстой холбоотой гэмт хэрэг - гэж Армен Улсын Эрүүгийн хуулийн 143,150, 1541, 1542-р зүйлд заасан гэмт хэргүүдийг хэлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

МӨРДӨН ШАЛГАХ ТУСГАЙ АЛБАНЫ СИСТЕМ, УГ АЛБАНД АЖИЛЛАГСАДЫГ ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ, ЗЭРЭГ ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ БА НӨХЦӨЛ

5-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны албан тушаалын систем

Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсдын албан тушаалыг дараах ангилалд хуваана. Үүнд:

- 1) Мөрдөн шалгах тусгай албаны дээд ангиллын албан тушаал:
 - Мөрдөн шалгах тусгай албаны дарга

- Мөрдөн шалгах тусгай албаны даргын орлогч
- 2) Мөрдөн шалгах тусгай албаны тэргүүлэх ангиллын албан тушаал:
 - Онц ноцтой гэмт хэргийг мөрдөн шалгах ахлах мөрдөн байцаагчид
- 3) Мөрдөн шалгах тусгай албаны гүйцэтгэх ангиллын албан тушаал:
 - Онц ноцтой гэмт хэргийн мөрдөн байцаагчид

6-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албанд алба хаахад тавигдах шаардлага

1. Мөрдөн шалгах тусгай албанд Армен Улсын их дээд сургуульд хуулийн мэргэжлээр суралцаж мэргэжлийн диплом, бакалаврын зэрэг авсан Армен Улсын иргэн, эсхүл гадаад оронд ижил мэргэжлээр суралцаж төгссөн боловч Армен Улсад дараах шаардлагад нийцүүлэн тухайн мэргэжлийн дипломыг хүлээн зөвшөөрсөн иргэн:
 - Цэргийн албыг заавал хаасан (эмэгтэйчүүд болон энэ зүйлийн 3-т заасан этгээдэд хамаарахгүй), эсхүл бэлтгэл офицер байх;
 - Армен хэлийг утга зохиолын түвшинд эзэмшсэн байх;
 - Энэ хуулийн 7-р зүйлд заасан шаардлагыг хангасан байх;
2. Мөрдөн шалгах тусгай албаны албан тушаалд томилж болохгүй иргэний бие эрхтний согог болон өвчний жагсаалтыг Засгийн газар батална.
3. Мөрдөн шалгах тусгай албаны албан тушаалд энэ зүйлийн 1-д заасан шаардлагыг хангахгүй боловч энэ хуулийн 12-р зүйлийн “б”-“д”-д заасан үндэслэлээр цэргийн үүрэгт албанаас чөлөөлөгдсөн, эсхүл “Цэргийн үүргийн тухай” Армен Улсын хуулийн 13-р зүйлд заасны дагуу 27 нас хүрэхээс өмнө цэргийн алба хаахаас түдгэлзсэн болон нөөцөд бүртгэгдсэн иргэнийг томилж болно.
4. Мөрдөн шалгах тусгай албаны албан тушаалд дараах иргэнийг томилохыг хориглоно:
 - шүүхийн шийдвэрээр чадамжгүй болсон, эсхүл эрхийн чадамжаа хязгаарлуулсан иргэн;
 - шүүхийн шийдвэрээр иргэний болон бусад албанд албан тушаалд томилохыг хориглосон;
 - хуулийн дагуу хэргийг хэрэгсэхгүй болгосон, ялын хугацаа дууссанаас үл хамааран гэмт хэрэг үйлдэж шийтгэл хүлээсэн;
 - гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байгаа;
 - энэ зүйлийн 1-д заасан шаардлагыг хангаагүй.
5. Мөрдөн шалгах тусгай албанд алба хаах насны дээд хязгаар 60 нас байна. Насны дээд хязгаарт хүрсэн тохиолдолд Мөрдөн шалгах тусгай албаны дарга алба хаах хугацааг 5 жил хүртэл хугацаагаар сунгаж болно. Мөрдөн шалгах тусгай албаны дарга, орлогчийн алба хаах насны дээд хязгаар 65 нас байна.

7-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны албан тушаалд томилох нөхцөл

1. Мөрдөн шалгах тусгай албаны даргын албан тушаалд уг албан тушаалд томилогдох хүртлээ тус албаны дээд ангиллын албан тушаалд ажиллаж байсан, эсхүл сүүлийн 5 жилд уг албаны тэргүүлэх албан тушаалд,

- эсхүл сүүлийн 7 жилд уг албаны гүйцэтгэх албан тушаалд ажиллаж байсан, эсхүл 10-аас доошгүй жил мөрдөн байцаагч болон прокуророор ажиллаж байгаа этгээдийг томилно.
2. Мөрдөн шалгах тусгай албаны даргын орлогчийн албан тушаалд уг албан тушаалд томилогдох хүртлээ сүүлийн 4 жилд уг албаны тэргүүлэх ангиллын албан тушаалд ажиллаж байсан, эсхүл сүүлийн 5 жилд уг албаны гүйцэтгэх албан тушаалд ажилласан, эсхүл мөрдөн байцаагч болон прокуророор 8-аас доошгүй жил ажилласан этгээдийг томилно.
 3. Мөрдөн шалгах тусгай албаны онц ноцтой гэмт хэргийг мөрдөх ахлах мөрдөн байцаагчийн албан тушаалд сүүлийн 2 жилд тус албанд мөрдөн байцаагчаар ажилласан этгээд, эсхүл мөрдөн байцаагч, прокуророор 4-өөс доошгүй жил ажилласан этгээдийг томилно.
 4. Мөрдөн шалгах тусгай албаны онц ноцтой гэмт хэргийн мөрдөн байцаагчаар уг албан тушаалд томилогдохоосоо өмнө прокурор, эсхүл мөрдөн байцаагчаар 3-аас доошгүй жил ажилласан этгээдийг томилно.
 5. Мөрдөн шалгах тусгай албаны тэргүүлэх болон гүйцэтгэх ангиллын албан тушаалд томилогдох этгээдийг хуульд заасан журмын дагуу өрсөлдөөнт сонгон шалгаруулалтаар сонгон авч бүрдүүлнэ.
 6. Мөрдөн шалгах тусгай албанд орон гарсан тохиолдолд үүрэг гүйцэтгэгчийг 1 жилээс дээшгүй хугацаагаар томилж болно.

8-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны албан тушаалтныг сонгон шалгаруулах конкурс

1. Сонгон шалгаруулах конкурсыг зөвхөн тэргүүлэх болон гүйцэтгэх албан тушаал дээр явуулна.
2. Мөрдөн шалгах тусгай албаны тэргүүлэх болон гүйцэтгэх ангиллын албан тушаалд орон гарсан тохиолдолд албаны дарга эдгээр сул орон тоон дээр 1 сарын дотор сонгон шалгаруулалт зарлана.
3. Сонгон шалгаруулалтын зарыг конкурс явуулахаас дор хаяж 1 сарын өмнө 3000 хувиас илүү тоогоор хэвлэгдэн гардаг өдөр тутмын сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана. Сонгон шалгаруулалт явуулах зарыг албаны дарга батална.
4. Сонгон шалгаруулалтын комисс энэ хуульд заасан шаардлага хангаагүй хүнийг сонгон шалгаруулалтанд оруулахгүй.
5. Сонгон шалгаруулалтыг 1 хүн хүсэлт гаргасан байсан ч заавал явуулна.
6. Сонгон шалгаруулалтыг комисс эхний ээлжинд ярилцлага хэлбэрээр явуулах ба оролцогчийн практик ур чадварыг шалгаж тодорхойлно.
7. Үүний дараа комисс хуралдаж оролцогч нэг бүрээр “дэмжсэн”, “дэмжээгүй” санал хураана.
8. Санал хураалтанд 50-иас дээш хувийн санал авсан оролцогсдыг тэнцсэнд тооцно.
9. Сонгон шалгаруулалтын дүнг тухайн өдөртөө багтааж нийтэд мэдээлнэ.
10. Сонгон шалгаруулалтын дүн гарч нийтэд мэдээлснээс хойш 1 цагийн дотор оролцогч өөрийн үнэлгээний талаар болон комиссийн гишүүдтэй холбоотой асуудлаар Мөрдөн шалгах тусгай албаны даргад бичгээр гомдол гаргаж болно.

11. Энэ хугацаанд оролцогчдын зүгээс бичгээр гомдол гаргаагүй тохиолдолд шалгалтын комиссын зүгээс сонгон шалгаруулалтанд тэнцсэн хүмүүсийн нэрсийг дүгнэлтийн хамт өргөн мэдүүлэх ба албаны дарга 3 ажлын өдөрт багтааж эдгээр тэнцсэн хүмүүсээс 1 хүнийг тухайн албан тушаалд томилно.
12. Хэрэв оролцогчдын зүгээс нэг ч хүн 50-иас дээш хувийн санал авч тэнцээгүй тохиолдолд уг конкурсыг дахин явуулна.
13. Хэрэв сонгон шалгаруулалтанд оролцохоор нэг ч хүн хүсэлт ирүүлээгүй, эсхүл хүсэлт гаргасан хүн нь хуульд заасан шаардлагыг хангаагүй, эсхүл шалгалт авах өдөр нэг ч оролцогч хүрэлцэн ирээгүй тохиолдолд конкурсыг хүчингүйд тооцож хуульд заасан журмын дагуу дахин шинээр явуулахаар зарлана.
14. Сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг Армен Улсын Иргэний албаны зөвлөл (Совет гражданской службы)¹⁰⁷ -өөс томилох ба журмыг Засгийн газар батална. Сонгон шалгаруулах комисс 7 гишүүнтэй байх ба үүнээс 3 нь хуульч-эрдэмтэн, 4 нь төрийн албан хаагч байна.
15. Комиссын даргыг комиссын гишүүд дундаас сонгон Армен Улсын Иргэний албаны зөвлөлийн дарга томилно.

9-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны даргыг томилох

1. Мөрдөн шалгах тусгай албаны даргыг Армен Улсын Ерөнхий прокурорын санал болгосноор Ерөнхийлөгч томилно. Ерөнхийлөгч энэ хуулийн 12-р зүйлд заасан үндэслэлийн дагуу Мөрдөн шалгах тусгай албаны даргыг албан тушаалаас чөлөөлж болно.
2. Мөрдөн шалгах тусгай албаны бусад албан тушаалд томилогдох этгээдийг Мөрдөн шалгах тусгай албаны дарга томилж, чөлөөлнө.

10-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албанд тангараг өргөх

1. Мөрдөн шалгах тусгай албанд анх удаа томилогдсон албан хаагч албаны даргын баталсан журмын дагуу Армен Улсын төрийн далбааны өмнө тангараг өргөнө. “Би (овог, нэр) БНАУ-ын Мөрдөн шалгах тусгай албанд ажиллахдаа Армен Улсын Үндсэн хууль, бусад хуулийг хэлбэрэлтгүй дагаж мөрдөн хүний эрх, эрх чөлөө, нийгмийн эрх ашиг, аюулгүй байдлыг сахин хамгаалж, Үндсэн хуулийн зарчмын эсрэг гэмт хэргээс ард иргэдээ хамгаалах үйл хэрэгт чин үнэнчээр зүтгэж, албаны үүргээ нэр төртэй, ухамсартайгаар биелүүлэхээ батлан тангараглаж байна” хэмээн тангараг өргөнө.
2. Албан хаагч бүр 1 удаа дээрх текстийг уншиж тангараг өргөнө.
3. Тангаргийн бичигт албан хаагчид гарын үсэг зурах ба хувийн хэрэгт хадгалуулна.

¹⁰⁷Совет Гражданской Службы - Иргэний (төрийн) албаны зөвлөл <http://www.csc.am/>

11-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албанд ажиглагсдад тавих хязгаарлалт

1. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсад эрдэм шинжилгээ, багшлах, уран бүтээл туурвихаас өөрөөр төрийн байгууллага, нутгийн удирдах байгууллага, ашгийн төлөө байгууллага болон бусад байгууллагад цалин хөлстэй ажил алба хавсран эрхлэхийг хориглоно.
2. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсдын эрдэм шинжилгээ, багшлах, уран бүтээл туурвих ажил эрхэлсний цалин хөлс нь тухайн ижил төрлийн ажил алба эрхэлж байгаа хүмүүсийн цалин хөлснөөс өндөр байж болохгүй.
3. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсад нь хувиараа хөдөлмөр эрхлэх эрхгүй.
4. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсад нь аж ахуйн нэгж, итгэлцэл дээр суурилсан нөхөрлөлд хувь хөрөнгө оруулах болон удирдлагад нь оролцох эрхгүй.
5. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсдад дараах зүйлийг хориглоно:
 - Өөрийн гэр бүлийн гишүүд, асран хамгаалагчийг төлөөлөхөөс бусад тохиолдолд гуравдагч этгээдийг төлөөлөх;
 - Албаны үүрэгтэй холбоотойгоор илтгэл тавьсан, илтгэл, нийтлэл хэвлүүлсэнийхээ төлөө урамшуулал авах;
 - Албан ажлын холбогдолтой мэдээлэл болон албаны өмч хөрөнгө, санхүүгийн болон мэдээллийн техник хэрэгсэл, материаллаг эд хөрөнгийг албаны бус зорилгоор ашиглах;
 - Албан үүргээ гүйцэтгэх явцдаа хуульд зааснаас бусад тохиолдолд бэлэг, мөнгө болон ажил үйлчилгээ авах.
6. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсад шууд хамаарал бүхий гэр бүл, төрөл садны хүмүүс (эцэг эх, эхнэр нөхөр, хүүхэд, ах, эгч, дүү, хадам эцэг эх, гэр бүлийн хүний ах, эгч, дүү)-тэй шууд удирдлагад хамтран ажиллахыг хориглоно.

12-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсдыг ажлаас чөлөөлөх

1. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсдыг дараах тохиолдолд ажлаас чөлөөлнө:
 - Армен Улсын иргэншлээс татгалзсан;
 - Өөрийн санаачилгаар бичгээр хүсэлт гаргасан;
 - Хуульд заасан насны дээд хязгаарт хүрсэн;
 - Тус байгууллагад орон тооны цомхотгол хийх, татан буулгах, өөрчлөн байгуулах явцад тухайн албан хаагчийн ажлын байр үгүй болсон, эсхүл нийт албан хаагчдыг цөөрүүлэх шаардлага гарсан бол;
 - Эрүүл мэнд, биеийн байдлаас шалтгаалан уг албанд тэнцэхгүй болсон;
 - Шүүхийн шийдвэрээр чадамжгүй болсон болон эрхээ хязгаарлуулсан;
 - Энэ хуулийн 21-р зүйлийн 1-р хэсгийн 2-5-д заасан зөрчлийн аль

- нэгийг 1 жилд 2 удаа гаргаж сахилгын арга хэмжээ авахуулсан бол;
- Энэ хуульд заасан албан хаагчдад хориглосон, хязгаарласан зүйл заалтыг зөрчсөн бол;
 - Мөрдөн шалгаж байгаа албан тушаалтанд хамааралтай гэмт хэрэг, зөрчлийг үндэслэлгүйгээр хаасан бол;
 - Албан тушаалтанд хамаарах гэм буруутайг тогтоосон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон бол;
 - Хүүхэд тээх, төрүүлэх, хүүхэд асрах чөлөөнөөс бусад тохиолдолд сүүлийн 12 сард 140 өдрөөс илүү, хөдөлмөрийн чадвар алдсанаас үүдэн 120 өдрөөс илүү хугацаагаар албан үүргээ гүйцэтгээгүй бол;
 - Сонгуульт болон улс төрийн албан тушаалд томилогдсон бол;
 - Аттестатчилах шалгалтын дүнгээр албан тушаал бууруулах санал гарсан боловч тухайн албан тушаалд сул орон гараагүй тохиолдолд;
 - Аттестатчилах шалгалтад 2 удаа хамрагдаагүй;
 - Албан хаагч нас барсан.

13-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсдын албан тушаалын зэрэг цол

1. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсад нь албан тушаалын дараах зэрэг цол олгоно:
 - 1) Хууль цаазын 3-р эрэмбийн төрийн зөвлөх;
 - 2) Хууль цаазын 1-р эрэмбийн зөвлөх;
 - 3) Хууль цаазын 2-р эрэмбийн зөвлөх;
 - 4) Хууль цаазын 3-р эрэмбийн зөвлөх;
 - 5) 1-р эрэмбийн зөвлөх;
 - 6) 2-р эрэмбийн зөвлөх;
 - 7) 3-р эрэмбийн зөвлөх.
2. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсад нь албан тушаалын цолны эрэмбэтэй байх ба дээрээс доош эрэмбэлэгдэнэ.
3. Хууль цаазын 3-р эрэмбийн төрийн зөвлөх цол нь хамгийн дээд зэрэг цол байх бөгөөд Ерөнхийлөгчөөс олгоно.
4. Бусад ажиллагсдын албан тушаалын хэргэм зэргийг Мөрдөн шалгах тусгай албаны дарга олгоно.
5. Албан тушаалын зэрэг, цолыг тухайн албан тушаалд дүйцэх хэргэм зэргийн дээд хязгаарт багтаан олгох ба хуульд өөрөөр заагаагүй бол өмнөх албан тушаалд ажилласан хугацаа дуусгавар болсноос хойш 15 хоногт багтаан цол ахиулна.
6. Албан тушаалын зэрэг цолыг тухайн хүнд бүх насаар нь олгоно.

14-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсдын албан тушаал ба зэрэг цолны дүйцэл

1. Мөрдөн шалгах тусгай албаны дээд ангилалын албан тушаалтны албан тушаалын зэрэг, цолны дээд хязгаар нь хууль цаазын 3-р эрэмбийн төрийн зөвлөх цол байна.

2. Мөрдөн шалгах тусгай албаны тэргүүлэх ангиллын албан тушаалтны албан тушаалын зэрэг, цолны дээд хязгаар нь хууль цаазын 1-р эрэмбийн төрийн зөвлөх цол байна.
3. Мөрдөн шалгах тусгай албаны гүйцэтгэх ангиллын албан тушаалтны албан тушаалын зэрэг, цолны дээд хязгаар нь хууль цаазын 2-р эрэмбийн төрийн зөвлөх цол байна.
4. Төрийн байгууллага, цэргийн болон тусгай албаны байгууллагад ажиллаж байгаад Мөрдөн шалгах тусгай албанд томилогдсон бол томилогдсон өдрөөс хойш 3 сар дотор өмнө нь олгогдсон төрийн албаны зэрэг дэв, цэргийн болон тусгай албаны зэрэг цолд нь дүйцэх зэрэг цолыг олгоно.
5. Төрийн бусад байгууллага, цэргийн болон тусгай албаны байгууллагуудаас олгосон зэрэг дэв, цол (албан тушаалын болон мэргэшлийн)-ыг хэрхэн дүйцүүлэхийг Засгийн газар тогтооно.

15-р зүйл. Албан тушаалын зэрэг цол олгох хугацаа

1. 3-р эрэмбийн зөвлөхийн цол зэрэг нь албан тушаалын анхан шатны зэрэг цолд тооцогдох ба мөрдөн шалгах тусгай албанд анх томилогдоход олгоно.
2. Дараа дараагийн эрэмбийн цол зэрэг нь ажилласан жилээс хамаарч дараах хугацаагаар олгогдоно:
 - 2-р эрэмбийн зөвлөх - 2 жил
 - 1-р эрэмбийн зөвлөх - 2 жил
 - Хууль цаазын 3-р эрэмбийн зөвлөх - 3 жил
 - Хууль цаазын 2- эрэмбийн зөвлөх - 4 жил.
3. Бусад эрэмбийн цол зэргийг олгоход ажилласан жил хамаарахгүй.
4. Ажилласан жилээс хамааруулан цол зэрэг олгохыг дараах шалтгаанаар хойшлуулж болно:
 - 1) аттестатчиллын шалгалтад тэнцээгүй буюу дахин сургалтад хамрагдахаар болсон;
 - 2) сахилгын шийтгэл хүртсэн;
 - 3) албан үүрэгтэй холбоотой асуудал болон эрүүгийн хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байгаа.

Дээрх шалтгааны улмаас албан тушаалын ээлжит хэргэм зэрэг олгохыг хойшлуулсан тохиолдолд дээрх зөрчлийг арилсанаас хойш 15 хоногийн дотор цол зэргийг олгоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ.
МӨРДӨН ШАЛГАХ ТУСГАЙ АЛБАНД АЖИЛЛАГСДЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ, БҮРЭН ЭРХ, ЭРХ ЗҮЙН БАТАЛГАА,
ЭРХ БА ҮҮРЭГ, АТТЕСТАТЧИЛАХ, ДАВТАН СУРГАХ

16-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсдын үйл ажиллагаанд хяналт тавих, бүрэн эрх

1. Мөрдөн шалгах тусгай албаны дарга хуульд заасан хэм хэмжээний хүрээнд тус албанд ажиллагсдыг өдөр тутмын удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.
2. Мөрдөн шалгах тусгай албаны дарга:
 - Ажиллагсдыг удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
 - Албаны үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой шийдвэр (тушаал, тогтоол, албан даалгавар) гаргах;
 - Албаны мөрдөн шалгалт хийх, түдгэлзүүлэх, мөрдөн шалгагчийг өөрчлөх шийдвэр гаргах;
 - Хуульд заасан нөхцөл үүссэн тохиолдолд мөрдөн шалгалт хийж буй байцаагчийн бүрэн эрхийг түр түдгэлзүүлэх;
 - Мөрдөн шалгах тусгай албаны дүрэм, бүтэц зохион байгуулалт, орон тооны хуваарилалт хийх;
 - Армен Улсын Ерөнхийлөгчид хандан Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсад дээд эрэмбийн хэргэм зэрэг олгуулах хүсэлт гаргах;
 - Мөрдөн шалгах тусгай албаны ажиллагсадтай холбоотой асуудлаар иргэдийн санал гомдол, хүсэлтийг хүлээн авах;
 - Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсдын материал-техникийн хангамжийг хариуцан зохион байгуулах;
 - Өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Мөрдөн шалгах тусгай албаны төсөв хөрөнгийг захиран зарцуулах;
 - Ажиллагсад зориулан мэргэжлийн болон тусгай сургалт зохион байгуулах;
 - Бүрэн эрхийнхээ хүрээнд ажиллагсдыг урамшуулах болон сахилгын шийтгэл ногдуулах;
 - Мөрдөн шалгах тусгай албаны үйл ажиллагааг төлөвшүүлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр санал дэвшүүлэх;
 - Мөрдөн шалгах тусгай албаны үйл ажиллагааг бусад төрийн болон төрийн бус байгууллагууд, орон нутгийн удирдах байгууллагуудтай уялдуулж, хамтран ажиллах;
 - Бусад хууль болон эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актуудаар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх.
3. Мөрдөн шалгах тусгай албаны дарга нь тус албаны үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээнэ.
4. Мөрдөн шалгах тусгай албаны даргын орлогч нь даргыг эзгүйд орлохоос гадна даргаас олгосон эрх, үүргийн хүрээнд энэ зүйлийн 1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

17-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны эрх зүйн баталгаа

1. Мөрдөн шалгах тусгай алба нь хараат бус байдлаар бүрэн эрхээ хэрэгжүүлдэг бие даасан статустай төрийн байгууллага мөн.
2. Мөрдөн шалгах тусгай албаны байцаагчдыг албан үүргээ гүйцэтгэхэд нь саад болох, хууль ёсны шаардлагыг нь биелүүлэхээс татгалзах, ажиллагсад болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд халдах, халдахыг заналхийлэх, айлган сүрдүүлэх үйлдэлд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
3. ~~Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсадтай холбоотой асуудлаар эрүүгийн хэрэг үүсгэх, хэргийн харьяалалыг тогтоох асуудлыг Армен Улсын Ерөнхий прокурор шийдвэрлэнэ.~~

(Энэ заалт 2010 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн “Мөрдөн шалгах тусгай албаны тухай” хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар хүчингүй болсон.)

18-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсдын эрх

1. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсад нь дараах эрхтэй:
 - Тухайн томилогдсон албан үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой эрх, үүргийг тодорхойлсон эрх зүйн актуудтай танилцах;
 - Өөрийн хувийн хэргийн бүх материал, үйл ажиллагааны үнэлгээ болон бусад бичиг баримттай танилцах, шаардлагатай бол тайлбар тодруулга гаргаж өгөх;
 - Албан үүргээ гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай мэдээ, материалыг холбогдох журмын дагуу гаргуулан авах;
 - Өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэр гаргах;
 - Хуульд заасан хязгаарын хүрээнд шагнал урамшуулал, нөхөн төлбөр авах;
 - Нийгмийн баталгаа болон нийгмийн хангамж эдлэх;
 - Эрх зүйн хамгаалалтад орох;
 - Холбогдох журмын дагуу албан тушаалын цол хэргэмээ нэмэгдүүлэх;
 - Аттестатчилах шалгалтын дүн болон албан үүрэгтэй нь холбоотой асуудлаар мөрдөн шалгахыг эсэргүүцэх;
 - Албаны үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулахтай холбоотой санал хүсэлт гаргах.
2. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагч хууль тогтоомж, эрх зүйн актуудаар тогтоосон бусад эрхээ эдэлнэ.

19-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсдын үүрэг

1. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсад дараах үүрэгтэй:
 - Үндсэн хууль, энэ хууль, Армен Улсын бусад хууль тогтоомжид тавигдсан шаардлагуудыг биелүүлж ажиллах;
 - зайлшгүй шаардагдах мэргэжлийн болон практик мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байх;

- хөдөлмөрийн сахилга батыг хангаж ажиллах;
 - ажлаа тайлагнах;
 - холбогдох журмын дагуу удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, тушаал шийдвэрийг биелүүлж ажиллах;
 - холбогдох журмын дагуу өргөдөл, гомдол, санал хүсэлтийг судлан шийдвэрлэж тогтоосон хугацаанд хариу өгөх;
 - Төрийн, албаны болон нууцын зэрэглэлтэй мэдээлэл, баримт материалтай танилцах, албан ажилдаа ашиглахдаа хууль журмыг баримталж ажиллах ба албан үүргээ гүйцэтгэх үедээ ч албанаас чөлөөлөгдсөн үедээ ч нууц хадгалах журмыг баримтлах;
 - хуульд заасны дагуу хөрөнгө орлогоо мэдүүлнэ.
2. Энэ хууль, бусад хууль эрх зүйн актуудаар Мөрдөн шалгах тусгай албаны ажиллагсдад хамаарах бусад үүргийг тогтоож болно.

20-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсдыг урамшуулах

1. Олон жил ажилласан, албаны үүргээ зохих хэмжээнд сайн үзүүлэлттэй гүйцэтгэсэн албан хаагчдад дараах төрлийн урамшуулал үзүүлнэ:
 - талархал илэрхийлэх;
 - нэг удаагийн мөнгөн урамшуулал олгох;
 - дурсгалын зүйл гардуулах;
 - хугацаанаас нь өмнө зэрэг цол олгох;
 - тухайн албан тушаалд олгогдох цол зэргийг нэг шатлал ахиулж олгох.
2. Албан хаагчдад үзүүлж буй урамшууллын хүрээнд өмнө нь ногдуулсан сахилгын арга хэмжээг хугацаанаас нь өмнө хүчингүй болгож болно.
3. Энэ зүйлийн 1-ийн 4, 5-д заасан урамшууллыг алба хаах хугацааны туршид нэг л удаа үзүүлнэ.
4. Нэг үндэслэлээр зөвхөн нэг төрлийн урамшуулал үзүүлнэ.
5. Хуулийн энэ зүйлд заасан урамшууллыг Мөрдөн шалгах тусгай албаны дарга үзүүлнэ.
6. Дээд эрэмбийн хэргэм зэрэг олгох урамшуулал үзүүлэх шаардлагатай бол албаны дарга Армен Улсын Ерөнхийлөгчид хүсэлт гаргана.

21-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчид сахилгын арга хэмжээ ногдуулах

1. Албан үүргээ хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүй, эсхүл хангалтгүй гүйцэтгэсэн тохиолдолд, мөн түүнчлэн өөр төрлийн зөрчил гаргасан бол дараах сахилгын шийтгэлийг ногдуулна. Үүнд:
 - 1) сануулах;
 - 2) хатуу сануулах;
 - 3) 3 сарын хүртэл албан тушаалын цалинг 10-30 хувь бууруулах;
 - 4) албан тушаалын зэрэглэлийг нэг шат бууруулах;
 - 5) албан тушаал бууруулах;
 - 6) ажлаас халах.

2. Энэ зүйлд заасан сахилгын шийтгэлийг Мөрдөн шалгах тусгай албаны дарга ногдуулна.
3. Албан тушаалын дээд ангиллын албан тушаалтанд энэ зүйлийн 1-ийн 4-т заасан сахилгын шийтгэлийг Армен Улсын Ерөнхийлөгч ногдуулна.
4. Мөрдөн шалгах тусгай албаны даргад сахилгын шийтгэлийг Армен Улсын Ерөнхийлөгч ногдуулна.

22-р зүйл. Сахилгын шийтгэл ногдуулах болон дуусгавар болгох журам

1. Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 6 сарын дотор тухайн албан хаагч өвчтэй, эсхүл амралттай байгаа эсэхээс үл хамааран сахилгын шийтгэл ногдуулах бөгөөд уг шийтгэл нь гаргасан зөрчилд тохирсон байх ёстой.
2. Шийтгэл ногдуулах тухай шийдвэрийг бичгэн хэлбэрээр гаргана. Нэг сахилгын зөрчилд нэг сахилгын шийтгэл ногдуулна.
3. Сахилгын шийтгэл ногдуулах шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор тухайн албан хаагчид мэдэгдэнэ.
4. Албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш жилийн хугацаанд дахин сахилгын зөрчил гаргаагүй бол тухайн шийтгэлийг дуусгавар болсонд тооцно. Энэ заалт нь хуулийн 21 дүгээр зүйлийн 1-ийн 3-6-д заасан сахилгын шийтгэлд хамаарахгүй.
5. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчид сахилгын шийтгэлийг зөвхөн дотоод мөрдөн шалгалтын үр дүнг үндэслэн ногдуулна.
6. Дотоод мөрдөн шалгалтын хугацаанд тухайн албан хаагчийг албан тушаалд хэвээр байлгах нь дотоод мөрдөн шалгалтын ажиллагаанд саад учруулна гэж үзвэл албан үүргээ гүйцэтгэх бүрэн эрхийг түр хугацаанд түдгэлзүүлж болно. Энэ тохиолдолд түүний цалин хөлсийг хэвээр олгоно.
7. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчид хамааралтай эрүүгийн хэргийг мөрдөн шалгаж байгаа тохиолдолд түүний бүрэн эрхийг хэрэг мөрдөн шалгаж дуусах хүртэл, эсхүл тухайн хэрэгтэй холбоотой шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл түр хугацаанд түдгэлзүүлнэ.

23-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагч аттестатчилалд хамрагдах журам болон нөхцөл

1. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчид 3 жилд 1 удаа заавал аттестатчилалд хамрагдана.
2. Аттестатчилал нь Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчийн шууд оролцоотойгоор явагдана.
3. Аттестатчилалд дараах албан хаагчид хамрагдахгүй. Үүнд:
 - 1) Мөрдөн шалгах тусгай албаны дарга, түүний орлогч;
 - 2) Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагч нь тухайн албан тушаалд ажилласан хугацаа 1 жил хүрээгүй бөгөөд өөрөө хамрагдах хүсэлтээ илэрхийлээгүй тохиолдолд;
 - 3) Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагч нь жирэмсэн, эсхүл 3 нас хүртэлх хүүхдээ асрах чөлөөтэй байгаа бөгөөд өөрөө хамрагдах хүсэлтээ илэрхийлээгүй тохиолдолд;

- 4) Тухайн жилд ажиллах насны хязгаар дууссаны улмаас ажлаас чөлөөлөгдөж буй албан хаагч.
4. Жирэмсний, эсхүл хүүхэд асрах чөлөөтэй байсан мөрдөн шалгах тусгай албаны албан хаагч наана нь аттестатчилалд орох хүсэлт гаргаагүй бол ажилдаа орсноос хойш 1 жилээс доошгүй хугацааны дараа аттестатчилалд хамрагдана.
5. Аттестатчилал явагдах үеэр амралттай, албан томилолттой, эсхүл хөдөлмөрийн чадвар түр алдсан албан хаагч ажилд орсноос хойш 2 сарын дотор аттестатчилалд хамрагдана.
6. Аттестатчилалд хамрагдсан Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчдын аттестатчиллын үр дүнг 1 сарын дотор танилцуулна.
7. Мөрдөн шалгах албаны албан хаагчийн шууд харьяалах удирдлага нь түүний ажил байдлын тодорхойлолтыг аттестатчилал явуулахаас 2 долоо хоногийн өмнө гаргана.
8. Ажил байдлын тодорхойлолтод албан хаагчийн ажлын туршлага болон хувийн зан байдлын талаарх мэдээллүүд, ажлын үнэлгээг тусгасан байх ёстой. Ажлын үнэлгээг албан хаагчийн өмнөх аттестатчиллаас хойш хамгийн сүүлд ажлаа тайлагнасан үр дүнг харгалзан түүний шууд харьяалах удирдлагын саналаар үнэлнэ.
9. Албан хаагч нь өөрийн ажил байдлын тодорхойлолттой аттестатчилал эхлэхээс өмнө долоо хоногийн хугацаанд танилцана.
10. Ажил байдлын тодорхойлолт энэ зүйлд заасан журмын дагуу хангалттай биш байгаа нь албан хаагчийн аттестатчиллын үнэлгээнд нөлөөлөхгүй.
11. Аттестатчиллын комиссын үүргийг энэ хуульд заасны дагуу шалгалтын комисс хэрэгжүүлнэ.
12. Шалгалтын комисс нь аттестатчилал явуулж дууссаны дараа дараах шийдвэрүүдээс аль нэгийг гаргана. Үүнд:
 - 1) эрхэлж буй албан тушаалдаа тэнцсэн;
 - 2) албан тушаал дэвших боломжтой;
 - 3) шагнал, урамшуулал олгох боломжтой;
 - 4) аттестатчиллыг 1 жилийн хугацаагаар хойшлуулах буюу албан хаагчийг давтан сургалтад хамруулах;
 - 5) эрхэлж буй албан тушаалдаа тэнцэхгүй.
13. Шалгалтын комисс нь Мөрдөн шалгах тусгай албаны даргад аттестатчилал явуулснаас хойш 7 хоногийн дотор үр дүнг танилцуулах бөгөөд дарга 10 хоногийн дотор шийдвэр гаргана.
14. Албан хаагч нь аттестатчиллын үр дүн болон шалгалтын комиссын шийдвэртэй танилцах эрхтэй бөгөөд 7 хоногийн дотор Мөрдөн шалгах албаны даргад гомдол гаргаж болно.
15. Албан хаагч нь түр хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдсан, эсхүл амралттай байгаа тохиолдолд ажилдаа орсноос хойш 3 хоногийн дотор аттестатчиллын үр дүнгээр холбогдох шийдвэрийг гаргана.
16. Аттестатчиллын үнэлгээг албан хаагчийн хувийн хэрэгт хадгална.

24-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчийг давтан болон тусгай сургалтад хамруулах

1. Мөрдөн шалгах тусгай албаны тэргүүлэх болон гүйцэтгэх албан тушаалын албан хаагчид 3 жилд 1 удаа давтан сургалтад заавал хамрагдана.
2. Заавал хамрагдах давтан сургалтын хугацаа 1 сар хүртэл үргэлжилж болно.
3. Аттестатчилах хугацаа болон давтан сургалтад хамруулахаар томилсон хугацаа хойшлогдсон тохиолдолд албан хаагч 3 сарын давтан сургалтад хамрагдана.
4. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагч нь тусгай сургалтад хамрагдсаны дараа галт зэвсэг болон хуульд заасан тусгай хэрэгслүүдийг биедээ авч явах, хадгалах, хэрэглэх эрхтэй болно.
5. Давтан болон тусгай сургалтад хамрагдах журам, нөхцөлийг Мөрдөн шалгах тусгай албаны дарга тогтооно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.**МӨРДӨН ШАЛГАХ ТУСГАЙ АЛБАНЫ АЛБАН ХААГЧИЙН
МАТЕРИАЛЛАГ, НИЙГМИЙН БОЛОН БУСАД БАТАЛГАА****25-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчдын цалин хөлс**

1. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчдад дараах цалин хөлс олгоно:
 - 1) албан тушаалын цалин;
 - 2) мөнгөн урамшуулал
2. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын үндсэн цалин, ажилласан жилийн нэмэгдэл болон цол зэргийн нэмэгдлээс бүрдэнэ.
3. Мөрдөн шалгах тусгай албаны албан тушаалын цалингийн систем дараах байдалтай байна;
 - 1) Албаны даргын албан тушаалын цалин нь Бүгд Найрамдах Армен Улсын Ерөнхий прокурорын албан тушаалын цалингийн 75 хувьтай тэнцэнэ;
 - 2) Албаны орлогч даргын цалин нь Мөрдөн байцаах тусгай албаны даргын албан тушаалын цалингийн 90 хувьтай тэнцэнэ;
 - 3) Ахлах мөрдөн байцаагчийн албан тушаалын цалин нь Мөрдөн шалгах тусгай албаны даргын албан тушаалын цалингийн 85 хувьтай тэнцэнэ;
 - 4) Мөрдөн байцаагчийн албан тушаалын цалин нь Мөрдөн шалгах тусгай албаны даргын албан тушаалын цалингийн 80 хувьтай тэнцүү байна.
4. Мөрдөн шалгах тусгай албаны даргын зэрэг дэвийн нэмэгдлээс хамааруулан албан хаагчдад албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг дараах байдлаар олгоно:

- 1) Хууль цаазын 3-р зэргийн төрийн зөвлөх - 75 хувь;
 - 2) Хууль цаазын 1- зэргийн зөвлөх - 65 хувь;
 - 3) Хууль цаазын 2-р зэргийн зөвлөх - 60 хувь;
 - 4) Хууль цаазын 3-р зэргийн зөвлөх - 55 хувь;
 - 5) Нэгдүгээр зэргийн зөвлөх - 50 хувь;
 - 6) Хоёрдугаар зэргийн зөвлөх - 45 хувь;
 - 7) Гуравдугаар зэргийн зөвлөх - 40 хувь.
5. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчдад мөрдөн шалгах тусгай алба, прокурор болон мөрдөн байцаагчаар ажилласан жил тутамд 4%-иар тооцож ажилласан жилийн нэмэгдэл олгох ба нэмэгдэл цалингийн хэмжээ нь үндсэн цалингийн хэмжээнээс хэтэрч болохгүй.
6. Мөрдөн шалгах тусгай албанд томилогдохоос өмнө прокурор, мөрдөн байцаагчаар ажиллаж байсан хугацааг ажилласан жилд оруулж тооцно.

26-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсдын ээлжийн амралт

1. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчид жил бүр ажлын 30 хоногийн цалинтай ээлжийн амралт эдлэх эрхтэй.
2. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагч нь цалингүй нэмэгдэл амралт эдлэх эрхтэй бөгөөд тус амралтыг олгох журам, нөхцөл, хугацааг Мөрдөн шалгах тусгай албаны дарга тогтооно.

27-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчийн тэтгэвэр тэтгэмж, нийгмийн хамгаалал

Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчийн тэтгэвэр тэтгэмж, нийгмийн хамгааллын асуудлыг Бүгд Найрамдах Армен Улсын “Цэргийн албан хаагчийн нийгмийн хангамжийн тухай” хуулиар зохицуулна.

28-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчийн үйл ажиллагаанд дахь бусад нийгмийн баталгаа

Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчид дараах баталгаагаар хангагдана:

- 1) хөдөлмөрийн нөхцөлийн болон аюулгүй ажиллагааны баталгаа;
- 2) Албан үүргээ гүйцэтгэх явцад албан хаагч болон тэдний гэр бүлийн гишүүдэд учирсан эд хөрөнгийн хохирлыг төрөөс хариуцан нөхөн төлөх хуульд заасан баталгаа;
- 3) Албан үүргээ гүйцэтгэх явцдаа амь нас нь эрсэдсэн, хөгжлийн бэрхшээлтэй болсон, бие эрхтний гэмтэл авсан, өвчилсөн тохиолдолд албан хаагч болон түүний гэр бүлд Бүгд Найрамдах Армен Улсын “Цэргийн албан хаагчийн нийгмийн хангамжийн тухай” хуульд заасны дагуу нөхөн төлбөр олгох.

29-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчийн аюулгүй байдал ба бие хамгаалах хэрэгсэл

1. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагч нь албаны гар буу болон бие хамгаалах тусгай хэрэгслүүдийг хадгалах, биедээ авч явах эрхтэй. Албаны гар буу болон бие хамгаалах тусгай хэрэгслүүдийг Бүгд Найрамдах Армен Улсын Засгийн газрын зөвшөөрсөн эрх бүхий байгууллага олгоно.
2. Албаны зэвсэг, бэлэн хамгаалалтын тусгай хэрэгслүүдийг хадгалах, биедээ авч явах журмыг Мөрдөн шалгах тусгай албаны даргын тушаалаар батална.
3. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагч, түүний гэр бүлийн гишүүд төрийн онцгой хамгаалалтад байна.
4. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагч болон түүний гэр бүлийн гишүүдийн халдашгүй байдал, гэр орон, ажлын байранд хууль бусаар халдах, заналхийлэх нөхцөл үүссэн тохиолдолд албан хаагчийн хүсэлтийн дагуу төрийн эрх бүхий байгууллагуудаас албан хаагч болон түүний гэр бүлийн гишүүд, гэр орон, ажлын байрыг яаралтай хамгаалалтад авах, аюулгүй болгох зэргээр шаардлагатай бүхий л арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

30-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчийн үнэмлэх болон тамга тэмдэг

Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчдад Мөрдөн шалгах тусгай албаны даргын баталсан нэгдсэн загварын үнэмлэх, мөн тэдний нэр дээр мөрдөн шалгах тусгай албанд бүртгэгдсэн дугаар бүхий хувийн тамга олгоно.

**ТАВДУГААР БҮЛЭГ.
МӨРДӨН ШАЛГАХ ТУСГАЙ АЛБАНЫ САНХҮҮЖИЛТ,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАНГАМЖ**

31-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны санхүүжилт, материал-техникийн хангамж

1. Мөрдөн шалгах тусгай албаны санхүүжилтийг Бүгд Найрамдах Армен Улсын хууль тогтоомжийн дагуу улсын төсөвт тусгагдсан зардлын хэмжээнд хийгдэнэ.
2. Мөрдөн шалгах тусгай албаны материал, техникийн хангамжийн журмыг Бүгд Найрамдах Армен Улсын Засгийн газар тогтооно.

32-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны ажлын алба ба техникийн үйлчилгээ

1. Мөрдөн шалгах төрийн тусгай албаны үйл ажиллагааг Бүгд Найрамдах Армен Улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу явуулна.

2. Мөрдөн шалгах тусгай албанд техникийн үйлчилгээ үзүүлж буй этгээдийг Бүгд Найрамдах Армен Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасан журмын дагуу албаны дарга томилж, чөлөөлнө.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ШИЛЖИЛТИЙН НӨХЦӨЛҮҮД

33-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчдыг анх аттестатчилах

Мөрдөн шалгах тусгай албаны албан хаагчдыг анх аттестатчилах ажиллагааг энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дараа явуулна.

34-р зүйл. Өмнө нь олгогдсон цол, алба хаасан хугацаа болон ажил

1. Мөрдөн шалгах тусгай албанд шинээр ажилд орсон албан хаагчдын өмнө нь бусад төрийн байгууллагуудад ажиллаж байхдаа авсан зэрэг дэв, цолыг энэ хуульд заасан журмын дагуу дүйцүүлэн олгоно.
2. Энэ хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-7-д заасан зэрэг дэвийг Бүгд Найрамдах Армен Улсын “Прокурорын байгууллагын тухай” хуулийн 37 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-10-т заасан зэрэг дэвтэй дүйцүүлэн тооцно. Мөрдөн шалгах тусгай албаны албан тушаалд томилогдсон этгээдийн өмнө нь авсан зэрэг цол тухайн албан тушаалын зэрэг цолны дээд хязгаараас давсан байвал зэрэг цолыг хэвээр үлдээнэ.
3. Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн прокурор, мөрдөн байцаагчийн албан тушаал хашиж буй этгээдэд хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-т заасан шаардлага хамаарахгүй болно.

35-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албанд төрийн тусгай үүрэг гүйцэтгэх журам

1. Мөрдөн шалгах тусгай албаны ажлын албыг 2008 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө байгуулна.
2. Мөрдөн шалгах тусгай алба байгуулагдах хүртэл уг албаны үүргийг Прокурорын байгууллагын ажлын албаны тухайн чиг үүргийг хариуцсан тусгай хэлтэс гүйцэтгэнэ. Энэхүү салбар нэгжид ажиллагсдыг Прокурорын ажлын албаны төрийн удирдах байгууллагын дүрэмд заасан журмын дагуу албан тушаалд томилж, чөлөөлнө.
3. Сонгон шалгаруулах комисс байгуулагдаж, үйл ажиллагааны журам батлагдах хүртэл Мөрдөн шалгах албаны албан хаагчдыг тус албаны дарга томилох бөгөөд томилогдсон албан хаагчид энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан хугацаанд магадлан итгэмжлэлд хамрагдана.

36-р зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг албан ёсоор нийтэлсний маргааш өдрөөс эхлэн хууль хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

БҮГД НАЙРАМДАХ АРМЕН УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Р.КОЧАРЯН
30.11.2007,
ЗР-255

1.2 ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Мөрдөн байцаах албаны тогтолцоо: ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн¹⁰⁸ 151 дүгээр зүйлд мөрдөн байцаах ажиллагааг хэрэгжүүлэх дараах байгууллагуудыг заасан байна. Үүнд:

ОХУ-ын Мөрдөн байцаах хороо (Следственный комитет РФ) нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу Үндсэн хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний эсрэг, хүний амь, эрүүл мэндийн эсрэг, төрийн эрх мэдэл, төрийн байгууллагуудын ашиг сонирхлын эсрэг, цэргийн албаны эсрэг гэмт хэргийг; хууль тогтоох бүх шатны байгууллагуудын төлөөлөгчид, шүүгчид, прокурорууд, өмгөөлөгчдөөс гадна хяналт, мөрдөн байцаах, цэргийн болон аюулаас хамгаалах байгууллагуудын албан тушаалтнуудын үйлдсэн гэмт хэргийг; насанд хүрээгүй хүүхэдтэй холбоотой хүнд, онц хүнд гэмт хэргийг мөрдөн байцаана.

ОХУ-ын Аюулаас хамгаалах албаны Мөрдөн байцаах хэлтэс (Следственный орган Федеральной Службы Безопасности) нь тагнуул болон терроризмын үйл ажиллагаа, төрийн нууцыг задруулсан, эх орноосоо урвасан, хил зөрчсөн, мансууруулах бодисын болон бусад хууль бус наймаатай холбоотой эрүүгийн хэргүүдийг мөрдөн байцаана.

ОХУ-ын Дотоод хэргийн яамны Мөрдөн байцаах хэлтэс (Следственный орган Внутренних Дел РФ) нь тус яамны тогтолцоон дахь мөрдөн байцаах байгууллагуудыг тэргүүлж, өөрийн эрхэлсэн асуудалд хамаарах гэмт хэргийг мөрдөн байцаана. Дотоод хэргийн яамны Мөрдөн байцаах хэлтсийн даргын үүрэгт ажлыг Дотоод хэргийн яамны орлогч сайд бөгөөд Мөрдөн байцаах хэлтсийн дарга хэрэгжүүлнэ. Тус хэлтсийн мөрдөн байцаах үйл ажиллагаанд ОХУ-ын Ерөнхий прокурор хяналт тавина.¹⁰⁹

ОХУ-д Мөрдөн байцаах үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн харилцааг дараах хууль тогтоомжуудаар зохицуулна:

¹⁰⁸"Уголовно-процессуальный кодекс Российской Федерации" от 18.12.2001 N 174-ФЗ

¹⁰⁹Положение о Следственном департаменте МВД РФ. Утвержден приказом МВД России от 1 июля 2011 г. N 780 "Об утверждении положения о Следственном департаменте Министерства внутренних дел РФ". Эх сурвалж: ДХЯ-ны цахим хуудас: <https://sledcom.ru> - 2019.04.04.

- Үндсэн хууль (1993 он)¹¹⁰;
- Мөрдөн байцаах хорооны тухай хууль (2010 он)¹¹¹;
- Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль (2001 он)¹¹²;
- Эрүүгийн хууль (1996 он)¹¹³;
- “ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны тухай” ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг (2010 он)¹¹⁴;
- “ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны үйл ажиллагааны тухай” ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг (2010 он)¹¹⁵.

Мөрдөн байцаах албаны түүхчилсэн лавлагаа: Мөрдөн байцаах бие даасан нэгжийг анх I Петр хааны санаачилгаар байгуулж байжээ. Байгуулагдсанаасаа хойш эзэн хаан, цагдаа, шүүх, прокурор зэрэг олон субъектэд хамаарагдаж байжээ. Энэхүү түүхэн үйл явцыг судлан үзэхэд шинжлэх ухааны аливаа судалгаа, эсхүл улс төрийн зарчимд тулгуурлаж байгаагүй, гагцхүү тухайн үеийн улс орны дээд удирдлагын улс төрийн нөлөөнөөс хамаарч байжээ.¹¹⁶



¹¹⁰Конституция РФ (12.12.1993). Эх сурвалж: <http://www.constitution.ru>

¹¹¹Закон О Следственном комитете РФ от 28.12.2010 N 403-ФЗ. Эх сурвалж:

https://sledcom.ru/documents/Pravovaja_informacija

¹¹²Уголовно-процессуальный кодекс РФ от 18.12.2001 г. № 174-ФЗ. Эх сурвалж: <http://ivo.garant.ru>

¹¹³Уголовный кодекс РФ от 13.06.1996 N 63-ФЗ. Эх сурвалж: <http://www.consultant.ru>

¹¹⁴Указ Президента РФ No 1182 от 27.09.2010 “Вопросы Следственного комитета РФ”.

Эх сурвалж: https://sledcom.ru/documents/Pravovaja_informacija - 2019.04.04.

¹¹⁵Указ Президента РФ No 14.01.2011 “Вопросы деятельности Следственного комитета РФ”.

Эх сурвалж: https://sledcom.ru/documents/Pravovaja_informacija - 2019.04.04.

¹¹⁶МБХ-ны түүх. Эх сурвалж: МБХ-ны цахим хуудас: <https://sledcom.ru> - 2019.04.04.

- 1713 он -** ОХУ-д хараат бус анхны мөрдөн байцаах нэгж нь I Петр хааны санаачилгаар байгуулагдсан байна. Энэ нэгж нь I Петр хааны шууд удирдлагад төрийн өндөр албан тушаалтнуудын авилгал, албан тушаалаа урвуулан ашиглах зэрэг гэмт хэргийг мөрдөн шалгаж байсан боловч I Петр хааны нас барсны (1725 он) дараа татан буулгажээ.
- 1808 он -** Мөрдөн байцаах нэгжийг I Александрын зарлигаар Дотоод хэргийн яамны харьяа хотын цагдаагийн газарт байгуулсан боловч төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой гэмт хэрэг улам бүр нэмэгдсэн байна.
- 1860 он -** Шүүхийн шинэчлэлийн хүрээнд мөрдөн байцаах нэгжийг шүүхийн харьяанд оруулсан бөгөөд тэр ондоо Оросын эзэнт гүрний 44 мужид 993 шүүхийн мөрдөн байцаагчдыг, 1867 онд цэргийн шүүхэд цэргийн мөрдөн байцаагчдыг тус тус томилов. Уг нэгжийг 1917 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр татан буулгав.
- 1918 он -** Мөрдөн байцаах хэлтсийг Хувьсгалын эсрэг үйлдэл, ажил санаатай саатуулахтай тэмцэх бүх Оросын тусгай хорооны бүтцэд байгуулжээ. Тусгай хороог 1922 оны 02 дугаар сард татан буулгасан байна.
- 1922 он -** Шүүхийн тухай хуульд заасны дагуу шүүхийн тогтолцоонд дараах мөрдөн байцаагчид ажиллаж байв. Үүнд:

Ардын шүүхэд	хэсгийн иргэдийн мөрдөн байцаагчид
Мужийн шүүхэд	ахлах мөрдөн байцаагчид
ЗСБНХУ-ын Дээд шүүхэд	онц чухал асуудал хариуцсан мөрдөн байцаагчид
ЗСБНХУ-ын Хууль зүйн ардын комиссариатад (хууль зүйн яам)	

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн дагуу 1923 оноос цэргийн асуудал хариуцсан мөрдөн байцаагчид ажиллаж эхлэв.

- 1928 он -** Мөрдөн байцаагчдыг ЗСБНХУ-ын Прокурорын харьяанд шилжүүлсэн байна. 1929 онд цэргийн прокурорын байгууллага өөрийн мөрдөн байцаагчидтай болов.
- 1936 он -** Прокурор болон мөрдөн байцаах байгууллагууд нь Хууль зүйн ардын комиссариат (буюу хууль зүйн яам, хожим нь Дотоод хэргийн ардын комиссариат буюу дотоод хэргийн яам)-ын харьяанаас гарсан байна.
- 1938 он -** 1938-1939 онд Дотоод хэргийн ардын комиссариат (буюу дотоод хэргийн яам)-ын улсын аюулаас хамгаалах болон цагдаагийн байгууллагуудад мөрдөн байцаах нэгжүүдийг тус тус байгуулжээ.
- 1960 он -** Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн дагуу "мөрдөн байцаагч" гэж прокурорын болон улсын аюулаас хамгаалах байгууллагуудын мөрдөн байцаагчдыг заасан байна.
- 1963 он -** ЗХУ-ын Дээд зөвлөлийн Тэргүүлэгчдийн шийдвэрээр Улсын аюулаас хамгаалах яаманд мөрдөн байцаах нэгжийг байгуулжээ.
- 1990 он -** Энэ үед эрүүгийн нийт хэргийн 90 хувийг Улсын аюулаас хамгаалах байгууллагын мөрдөн байцаагчид, үлдсэн хувийг прокурорын газрын мөрдөн байцаагчид хянан шалгаж байжээ.

Эх сурвалж: МБХ-ны цахим хуудас: <https://sledcom.ru>

- 2007 онд улс төрийн харьцангуй тогтвортой бөгөөд нэгдмэл нөхцөл байдал бүрэлдэж 06 дугаар сард нь Эрүүгийн байцаан шийтгэх тухай, Прокурорын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан нь мөрдөн байцаах нэгжийг харьцангуй бие даасан статустай болгох томоохон шинэчлэл хийгдэж Прокурорын байгууллагын дэргэдэх Мөрдөн байцаах хороог байгуулсан байна.

Үүнтэй холбогдуулан Прокурорын тухай хуульд дараах зохицуулалтыг нэмж тусгасан. Үүнд:

- Прокурорын байгууллагын дэргэдэх Мөрдөн байцаах хорооны даргыг ОХУ-ын Ерөнхийлөгчийн санал болгосноор ОХУ-ын Холбооны хурал (Парламент)-ын Холбооны зөвлөл томилж, чөлөөлнө.
- Прокурорын байгууллагын дэргэдэх Мөрдөн байцаах хорооны даргын Нэгдүгээр орлогч болон бусад орлогчдыг Прокурорын байгууллагын дэргэдэх Мөрдөн байцаах хорооны даргын санал болгосноор ОХУ-ын Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.
- Прокурорын байгууллагын дэргэдэх Мөрдөн байцаах хорооны дарга нь тус хорооны ажилтнуудыг томилж, чөлөөлөх ба түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, харьяа нэгжүүдийн эрх, үүргийг батална.

Түүнчлэн Прокурорын байгууллагын дэргэдэх Мөрдөн байцаах хорооны даргын албан үүргийг ОХУ-ын Ерөнхий прокурорын Нэгдүгээр орлогч гүйцэтгэж, харин тус хорооны мөрдөн байцаагчдын албан үүргийг прокурорын ажиллагсад хэрэгжүүлж байсан.

Прокурорын байгууллагын дэргэдэх Мөрдөн байцаах хорооны зохион байгуулалтын загвар нь захиргааны бус байгууллагын загвар болох бараг бүх уламжлалт шинжийг өөртөө агуулж байсан: зохион байгуулалтын бие даасан байдал, шууд захирагдах байгууллага байхгүй байсан нь мөрдөн байцаалтын объектив бөгөөд шударга байдлыг баталгаажуулсан. Өөрөөр хэлбэл, Мөрдөн байцаах хороо Прокурорын дэргэд гэдэг нь захиргааны бус зөвхөн эрх зүйн шинжийг агуулж байжээ.

Гэвч судлаачдын үзэж байгаагаар I Петр хааны үүсгэн байгуулж байсан мөрдөн байцаах бие даасан нэгжийн загварыг 2011 онд бүрэн сэргээсэн гэж үзэж байгаа аж.¹¹⁷ Учир нь 2010 онд ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны тухай хууль¹¹⁸ батлагдаж 2011 онд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш ОХУ-ын Прокурорын байгууллагын гадна Мөрдөн байцаах хороог байгуулах нь мөрдөн байцаах байгууллагуудын процессийн үйл ажиллагаанд хяналт тавих прокурорын бүрэн эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, мөрдөн байцаалтын объектив хандлагыг нэмэгдүүлснээр Эрүүгийн байцаан шийтгэх

¹¹⁷МБХ-ны түүх. Эх сурвалж: МБХ-ны цахим хуудас: <https://sledcom.ru> - 2019.04.04.

¹¹⁸ФЗ О Следственном комитете РФ от 28.12.2010 г. № 403-ФЗ.

ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны тухай хуулиар түүний үйл ажиллагааны зорилго, зарчим, бүтэц, зохион байгуулалт, түүний удирдлагын томилох, чөлөөлөх, албан хаагчдад тавигдах шаардлага, хязгаарлалт, хориг, тэдэнд олгох тусгай цол, цолны нэмэгдэл болон мөнгөн урамшууллын хэмжээ, шагнал урамшуулал, төрийн хамгаалалтад байх баталгаа, нийгмийн хангамж, заавал хамрагдах даатгалын төрөл, хүлээлгэх хариуцлага, албан үүргээс нь чөлөөлөх болон үйл ажиллагаанд нь тавих прокурорын хяналт зэрэг харилцааг зохицуулна.

тухай хуулийн хэрэгжилт болон иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хамгаалахад ахиц дэвшил гарна хэмээн энэ хуулийн төслийн танилцуулгад тэмдэглэсэн байна.

Өнөөгийн энэхүү босоо тогтолцооны онцлог нь Мөрдөн байцаах хорооны удирдлагыг ОХУ-ын Ерөнхийлөгч хэрэгжүүлэх бөгөөд үүнийг Мөрдөн байцаах хорооны тухай хуулийн 1.3, “ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны үйл ажиллагааны тухай” ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2011 оны 38 дугаар зарлигийн¹¹⁹ хавсралтаар баталсан МБХ-ны дүрмийн 3-т тус тус заасан байна.

Мөрдөн байцаах хорооны тухай хуулийн 13.2, 14.2, 15.6, МБХ-ны дүрмийн 16-д тус тус заасны дагуу ОХУ-ын Ерөнхийлөгч нь МБХ-ны дарга, түүний 1-р орлогч, бусад орлогчдыг (МБХ-ны даргын санал болгосноор); ерөнхий болон ОХУ-ын субъектүүдийн мөрдөн байцаах газрын дарга, тэдгээрийн 1-р орлогчид, бусад орлогчдыг; бусад удирдах албан тушаалтнуудыг томилж, чөлөөлнө.

Мөрдөн байцаах хорооны тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу МБХ-ны дарга жил бүр ОХУ-ын Ерөнхийлөгчид ажлаа тайлагнана. Мөн МБХ-ны мөрдөн байцаах үйл ажиллагаанд ОХУ-ын Ерөнхий прокурор болон бусад прокурорууд хяналт тавихаар Мөрдөн байцаах хорооны тухай хуулийн 44 дүгээр зүйлд тус тус заасан байна.

Мөрдөн байцаах хорооны эрх хэмжээ: Мөрдөн байцаах хорооны тухай хуулийн 6.1-д зааснаар, Холбооны болон ОХУ-ын субъектүүдийн төрийн байгууллагууд, нутгийн өөрөө удирдах байгууллагууд, олон нийтийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгслийнхэн, тэдгээрийн төлөөлөгчид, албан тушаалтнуудын зүгээс МБХ-ны үйл ажиллагаанд болон ажилтнуудад нөлөөлөхийг хориглоно.

МБХ-ны ажилтны эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль тогтоомжийн дагуу байцаан шийтгэх үйл ажиллагаа явуулахдаа Мөрдөн байцаах хорооны тухай хуулийн 7 дугаар зүйл, МБХ-ны дүрмийн 8-д заасан эрх хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- гэмт хэргийн талаарх мэдээллийг шалгах, эрүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах зорилгоор холбооны болон ОХУ-ын субъектүүдийн төрийн байгууллагууд, нутгийн өөрөө удирдах байгууллагууд, бусад аж ахуйн нэгж, байгууллага (өмчлөл харгалзахгүй)-д **чөлөөтэй нэвтрэх, баримт бичиг, статистик, бусад мэдээлэлтэй танилцах эрхтэй;**
- гэмт хэргийг таслан зогсоох, сэжигтэнг мөрдөн байцаах, гэмт хэрэг болсон, эсхүл болох тухай мэдээллийг шалгах зорилгоор иргэдийн эзэмшлийн орон сууц, байр, газарт **нэвтрэх эрхтэй;**
- баримт бичгийн шалгалт хийх, баримт бичиг, эд зүйл, объект, цогцост шинжилгээ хийх холбогдох мэргэжилтэн томилохыг байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага, албан тушаалтнаас **шаардах эрхтэй;**
- шүүхийн өмнөх ажиллагаанд тайлбар авах болон мөрдөн байцаах зорилгоор албан тушаалтан болон бусад этгээдийг **дуудах эрхтэй.**

¹¹⁹Указ Президента РФ от 14.01.2011 № 38 “Вопросы деятельности СК РФ”.

МБХ-ны ажилтны гэмт хэргийн талаарх мэдээллийг шалгах, мөрдөн байцаалт явуулах болон бусад эрх мэдлээ хэрэгжүүлэх явцдаа тавьсан шаардлага (хүсэлт, үүрэг, чиглэл)-ыг бүх байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, бусад этгээдүүд нэн даруй, эсхүл заасан хугацаанд биелүүлэхийг Мөрдөн байцаах хорооны тухай хуулийн 7.2-т тогтоосон байна.

Мөрдөн байцаах хорооны чиг үүрэг: Мөрдөн байцаах хорооны тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар МБХ нь мөрдөн байцаах чиглэлээр эрүүгийн гэмт хэргийн тухай мэдэгдэл, мэдээллийг шалгах, эрүүгийн гэмт хэргийн мөрдөн байцаалт, процессийн хяналт, криминалистик, шүүхийн шинжилгээ болон шалган байцаах ажиллагааг хэрэгжүүлэхийн зэрэгцээ мөрдөн байцаах байгууллагуудын үйл ажиллагааг хянах чиг үүргийг гүйцэтгэнэ.

Түүнчлэн эрхлэх асуудлынхаа хүрээнд бодлого, эрх зүйн баримт бичиг боловсруулахад дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- төрийн бодлого болон хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ба түүнийг сайжруулах талаар санал боловсруулах;
- хууль тогтоомж боловсруулан ОХУ-ын Ерөнхийлөгч, Засгийн газарт танилцуулах;
- ОХУ-ын Ерөнхийлөгч, Засгийн газрын даалгавраар хууль тогтоомжийн төсөлд эрх зүйн шинжилгээ хийхэд оролцох гэх мэт.

ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны үйл ажиллагаа өргөн цар хүрээг хамрах бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 151.2-т зааснаар дараах 4 чиглэлээр эрүүгийн хэргийг мөрдөн байцаах ажиллагаа явуулна. Үүнд:

1. Үндсэн хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний эсрэг, хүний амь, эрүүл мэндийн эсрэг, нийтийн аюулгүй байдлын эсрэг, төрийн эрх мэдэл, төрийн алба, орон нутгийн байгууллагын ашиг сонирхлын эсрэг, захиргааны хариуцлагын эсрэг, шударга ёсны эсрэг, цэргийн албаны эсрэг гэх мэт эрүүгийн гэмт хэргийг;
2. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 447 дугаар зүйлд заасан төрийн өндөр албан тушаалтнууд, тэдгээрийн албан тушаалын болон мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой эрүүгийн гэмт хэргийг:
 - ОХУ-ын Холбооны зөвлөл, Төрийн думын гишүүд, ОХУ-ын субъектүүдийн хууль тогтоох байгууллагын төлөөлөгчид, орон нутгийн сонгуульт байгууллагуудын төлөөлөгчид, гишүүд, албан тушаалтан нар;
 - ОХУ-ын Үндсэн хуулийн болон бусад шүүхийн бүх шатны шүүгчид;
 - ОХУ-ын Хяналтын хороо (Счетная палата Российской Федерации)-ны дарга, түүний орлогчид, ОХУ-ын Хяналтын хорооны аудиторуд;
 - ОХУ-ын Хүний эрхийн омбудсмэн;
 - ОХУ-ын Ерөнхийлөгч асан, мөн ОХУ-ын Ерөнхийлөгчид нэр дэвшигчид;
 - прокуроруд;
 - МБХ-ны дарга болон мөрдөх байгууллагуудын удирдлагууд;
 - мөрдөн байцаагчид;

- өмгөөлөгчид;
 - сонгуулийн хороо болон бүх нийтийн санал асуулгыг зохион байгуулах хорооны шийдвэрлэх саналын эрхтэй гишүүд;
 - Төрийн думын сонгуульд нэр дэвшигчид, ОХУ-ын субъектүүдийн хууль тогтоох байгууллагад нэр дэвшигчид.
3. ОХУ-ын хууль, хүчний дараах байгууллагын албан тушаалтнууд, тэдгээрийн албан тушаалын болон мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой эрүүгийн гэмт хэргийг
- МБХ-ны;
 - аюулаас хамгаалах байгууллагуудын;
 - Тагнуулын албаны;
 - Хамгаалалтын албаны;
 - Дотоод хэргийн яамны харьяа байгууллагуудын;
 - эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын;
 - гаалийн байгууллагуудын;
 - цэргийн сургалтад хамрагдаж байгаа цэргийн албан хаагчдыг, иргэдийг;
 - Зэвсэгт хүчний цэргийн болон энгийн албан хаагчдыг.
4. Насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн болон насанд хүрээгүй хүүхэдтэй холбоотой хүнд, онц хүнд гэмт хэргүүд орно.

1.3. МОНТЕНЕГРО УЛС¹²⁰

Монтенегро Улсын Прокурорын газрын дэргэд мөрдөн байцаах чиг үүрэг бүхий Улсын тусгай прокурорын алба ажилладаг. Тус албаны үйл ажиллагааг 2015 оны 02 дугаар сарын 26-нд батлагдсан “Монтенегро Улсын тусгай прокурорын албаны тухай хууль”¹²¹ (law on special public prosecutor’s office of Montenegro)-аар зохицуулсан байна.

Энэхүү хууль нь Улсын тусгай прокурорын албаны бүтэц зохион байгуулалт, шүүх эрх мэдэл, Улсын тусгай прокурорын албаны дарга болон тусгай прокуроруудыг сонгох шаардлага ба процедур, бусад төрийн болон захиргааны албадуудтай хэрхэн харилцах хэм хэмжээ, албаны үйл ажиллагаанд холбогдох бусад харилцааг зохицуулна.

Хуульд зааснаар Улсын тусгай прокурорын алба нь Монтенегро Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд бие даасан, хараат бусаар Улсын прокурорын газрын дотор байгуулагдана. Тус алба нь бүх үйл ажиллагаагаа өөрийн эрх мэдлийн хүрээнд явуулж, Подгорика¹²² дахь Дээд шүүхийн тусгай хэлтсийн өмнө хариуцна.

¹²⁰<https://www.tuzilastvog.me/index.php/en/special-state-prosecutor-s-office>

¹²¹[https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2015\)012-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2015)012-e)

¹²²Монтенегро улсын нийслэл

Хуулийн 3-р зүйлд зааснаар Улсын Тусгай прокурорын алба нь дараах гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэнэ. Үүнд:

1. хуулиар заасан хугацаа харгалзахгүйгээр аливаа зохион байгуулалттай гэмт хэрэг;
2. өндөр түвшний (их хэмжээний) авлигал:
 - а) хэрвээ төрийн албан тушаалтан¹²³ дараах гэмт хэргүүдийг үйлдсэн бол:
 - албан тушаалаа урвуулан хэрэглэсэн;
 - албан үүргээ гүйцэтгэх үедээ хууран мэхэлсэн;
 - албан тушаалын нөлөөгөө худалдаалсан;
 - албан тушаалын нөлөөгөө худалдаалах сэдэл төрүүлсэн;
 - авлигал өгсөн;
 - авлигал авсан.
 - б) хэрвээ дараах гэмт хэргийг үйлдээд 40.000 евро-оос давсан орлого олсон бол:
 - үйл ажиллагаанд албан тушаалаа урвуулан ашигласан;
 - эдийн засагт эрх мэдлээ урвуулан ашигласан.
3. мөнгө угаасан;
4. терроризм ба;
5. цэргийн гэмт хэрэг.

Дээр заасан эрүүгийн хэргийн гэм буруутныг хянан шийдвэрлэх ажлыг Улсын прокурорын албаны тэргүүний хувиар Ерөнхий тусгай прокурор, улсын прокурорын хувиар тусгай прокурорууд гүйцэтгэх ба, тэдний орон тоог Прокурорын зөвлөл Улсын прокурорын үйлчилгээний хуулийг үндэслэн тогтооно.

Ерөнхий тусгай прокурор нь өөрийн болон Тусгай прокурорын албаны ажлыг Улсын дээд прокурорт, харин тусгай прокурорууд нь ажлаа Ерөнхий тусгай прокурорт тус тус тайлагнана.

Улсын тусгай прокурорын албаны үйл ажиллагааг Улсын прокурорын үйлчилгээний тухай хуулийн дагуу боловсруулсан Удирдлагын төлөвлөгөөнд үндэслэн Улсын дээд прокурорын алба хянана.

Тусгай прокурорын албаны үйл ажиллагааны санг Улсын прокурорын үйлчилгээнд төсөвлөсөн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгон хуваарилна.

Хуулийн 2-р бүлэгт Улсын тусгай прокурорын албаны бүтэц, зохион байгуулалтыг зохицуулсан байна. Тухайлбал:

¹²³Энэхүү хуулинд төрийн албан тушаалтан гэдгийг төрийн эрх мэдэлтэн, төрийн захиргааны эрх мэдэлтэн, нутгийн өөрөө удирдах эрх мэдэлтэн, нутгийн захиргааны эрх мэдэлтэн (цаашид албаны эрх мэдэлтэн гэнэ), бие даасан эрх мэдэлтэн, зохицуулах эрх мэдэлтэн, олон нийтийн байгууллага, олон нийтийн аж ахуйн нэгж, эсхүл аливаа бизнесийн байгууллага, эсхүл хуулийн этгээд зэрэг олон нийтийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч, эсхүл нийтийн ашиг сонирхлын төлөөх үйл ажиллагаа эрхэлдэг төрийн мэдлийн үйл ажиллагааг эрхлэгчид, сонгогдсон, нэр дэвшсэн, эсхүл томилогдсон хүнийг, эсхүл сонгогдсон, нэр дэвшсэн, томилогдсон албаны эрх мэдэлтэй хүнийг ойлгоно.

Улсын тусгай прокурорын алба нь тасаг, албадаас бүрдэнэ. Тасгууд (divisions) нь эрүүгийн хэргийг хянах, санхүүгийн мөрдөн байцаах, дүн шинжилгээ ба судалгаа, олон улсын хамтын ажиллагааны зэрэг ажил үүргийг гүйцэтгэх зорилгоор зохион байгуулагддаг бол албадууд (Services) нь олон нийттэй харилцах, мэргэжлийн, захиргааны болон техникийн үйл ажиллагааг хангах үүднээс зохион байгуулагдана.

Тасгууд: Эрүүгийн гэмт хэрэгтнийг хянан шийдвэрлэх тасаг нь урьдчилсан байцаалт, мөрдөн байцаалт, тэрчлэн төрийн бусад албадуудтай хамтын ажиллагаатай бүхий л ажил үүргийг гүйцэтгэнэ.

Санхүүгийн мөрдөн байцаах тасаг нь гэмт хэргийн үйлдлийн явцад олсон орлого, гэмт хэрэг үйлдсэнээр олсон үл хөдлөх хөрөнгө зэргийг шалган тогтоох зорилгоор мэдээлэл цуглуулах, мөн үл хөдлөх хөрөнгийг хураан битүүмжлэх арга хэмжээг авна.

Дүн шинжилгээ, судалгааны тасаг нь төрийн бусад албадтай мэдээлэл солилцох, тэдгээрт буй мэдээллийн санг хэрэглэх, судлах, хэргийн статистик тайлан ба хяналт зэргийг ашиглах нөхцөлүүдийг бүрэлдүүлэн, баяжуулах үүргийг гүйцэтгэнэ.

Олон улсын хамтын ажиллагааны тасаг нь бусад улс болон олон улсын байгууллагуудын нэр хүндтэй эрх мэдэлтнүүдтэй хамтран ажиллах, Улсын тусгай прокурорын албаны эрх мэдлийн хүрээнд хамаарах гэмт хэргийг хянан шийдвэрлэх зорилго бүхий олон улсын гэрээ хэлэлцээрийн үндсэн дээр байгуулагдаж буй хамтарсан мөрдөн байцаах багийн гишүүдийг томилох зэрэг ажил үүргийг гүйцэтгэнэ.

Улсын тусгай прокурорын алба нь Ерөнхий тусгай прокурор болон тусгай прокурор, зохих тооны зөвлөгч, бусад төрийн албан хаагчдын орон тоотой байна.

Ерөнхий тусгай прокурор нь таван жилийн хугацаатай сонгогдоно. Тусгай прокурор нь хэрвээ улсын прокуророор, эсхүл шүүгчээр наанадаж дөрвөн жил ажилласан бол тэтгэврийн насанд хүртлээ сонгогдоно. Харин улсын прокуророор, эсхүл шүүгчээр наанадаж дөрвөн жил ажиллаагүй бол тусгай прокуророор дөрвөн жилийн хугацаатай сонгогдоно.

Хуулийн 4-р бүлэгт Улсын тусгай прокурорын албаны цагдаагийн газартай хэрхэн харилцан ажиллах талаар зохицуулсан. Тухайлбал: хуулийн 3 дугаар зүйлд заасан гэмт хэрэгтэй холбогдох цагдаагийн ажил үүргийг Улсын тусгай прокурорын цагдаагийн тусгай нэгжийн цагдаагийн албан хаагчид гүйцэтгэнэ. (цаашид Цагдаагийн тасаг гэнэ) Цагдаагийн тасгийн дарга нь VII1 түвшний боловсрол мэргэжилтэй, их сургуулийн зэрэгтэй байх шаардлага бүхий цагдаагийн мэргэжлээр наанадаж 8 жил ажилласан ажлын туршлагатай хүн байна. Цагдаагийн тасгийн даргыг цагдаагийн хэрэг хариуцсан захиргааны

эрх мэдэлтэн (цаашид Цагдаагийн захиргаа гэнэ) Ерөнхий тусгай прокурортой зөвшилцөн томилно. Цагдаагийн тасгийн ажилтан нь VII1 түвшний боловсрол мэргэжилтэй, их сургуулийн зэрэгтэй байх шаардлага бүхий цагдаагийн мэргэжлээр наанадаж 4 жил ажилласан ажлын туршлагатай хүн байна.

Цагдаагийн ажилтны үүрэг хариуцлагын тухайд цагдаагийн тасгийн дарга болон ажилтан нь Ерөнхий тусгай прокурор, эсхүл холбогдох тусгай прокурорын өгсөн тушаалыг гүйцэтгэнэ. Ерөнхий тусгай прокурорын зөвшөөрөлгүйгээр цагдаагийн тасгийн дарга болон ажилтан цагдаагийн захиргаанд ямар нэгэн өөр албан тушаал хашихаар, эсхүл ажил үүрэг гүйцэтгэхээр шилжин томилогдохгүй.

Хуулийн 5-р бүлэгт Улсын тусгай прокурорын албаны мөрдөн байцаагчдын үйл ажиллагаа, эрх үүргийн талаар хуульчилсан байна. Тухайлбал:

Улсын тусгай прокурорын албаны эрх мэдлийн хүрээний гэмт хэргийг мөрдөн байцаах зорилгоор Ерөнхий тусгай прокурор нь татвар, гааль, мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх ба мөрдөн байцаах ажил хэргийн хамааралтай захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдад зарим тодорхой ажил хэргийг шилжүүлэн өгч болно (цаашид мөрдөн байцаагчид гэнэ).

Дээр заасан албан байгууллагуудын дарга нар Ерөнхий тусгай прокурорын хүсэлтээр хяналт шалгалтын ажил үүргийг гүйцэтгэх ажлын туршлага, чадвартай болон Улсын тусгай прокурорын албаны эрх мэдлийн хүрээний гэмт хэргийг мөрдөн байцаах ажилд шаардагдах бусад мэдлэгтэй төрийн албан хаагчдын нэрсийн жагсаалтыг гаргаж өгнө.

Ерөнхий тусгай прокурорын санал болгосноор Улсын дээд прокурор жил тутмын мөрдөн байцаагч нарын нэрсийн жагсаалтыг хүлээн авч, улмаар энэхүү дээр заасан байгууллагын удирдлагууд болон Ерөнхий тусгай прокурорт хүргүүлнэ. Мөрдөн байцаагч нь тусгай прокурорын тушаалыг биелүүлэх ажлыг түүний зааварчилгаа, өөрийн ажил мэргэжлийн дүрэм журам, Эрүүгийн хэргийн хуулийн дагуу гүйцэтгэнэ. Мөрдөн байцаагч нь хуульд заасан үүрэг даалгаврыг тусгай прокурорын заасан хугацаанд гүйцэтгэх ба энэхүү ажлыг гүйцэтгэж буй тухайд өөрийн шууд харьяалах даргад мэдүүлэн илтгэхгүй байж болно. Хэрвээ мөрдөн байцаагч ямарваа хүндэтгэх шалтгаангүйгээр тусгай прокурорын тушаал ба зааварчилгааны дагуу ажиллаж чадаагүй, эсхүл эсрэгээр ажилласан тохиолдолд тусгай прокурор энэ тухайд түүний шууд харьяалах удирдлагад мэдэгдэнэ.

Тусгай прокурорын тушаалыг гүйцэтгэж чадаагүй ба энэхүү зүйлийн гуравдугаар доголд заасан утгаар тусгай прокурорын тушаал, заавраас зөрчсөн үйлдэл нь мөрдөн байцаагчийн албан үүргээ ноцтой зөрчсөн хэрэг болно.

Энэхүү зүйлийн гуравдугаар доголд заасан тохиолдлуудад мөрдөн байцаагчийн шууд харьяалах албаны удирдлагаас түүнд сахилгын хариуцлага ногдуулна.

Мөрдөн байцаагч нь Авлигалаас урьдчилан сэргийлэх хуулийн дагуу өөрийн үл хөдлөх хөрөнгө ба орлогын тухай, мөн өөрийн гэр бүл ба хууль ёсны хамтрагч, хүүхдүүдийн үл хөдлөх хөрөнгө ба орлогын талаар мэдүүлнэ.

Хуульд тусгайлан зааснаар тухайлсан нарийн төвөгтэй хэргүүдэд Ерөнхий тусгай прокурор нь тусгай прокурор, цагдаагийн тасгийн ажилтан, зохих бусад байгууллагын төрийн албан хаагчдаас бүрдсэн мөрдөн байцаах тусгай багийн байгуулж болно. Мөрдөн байцаах багийн ахлагч нь тусгай прокурор байх ба тухайн мөрдөн байцаах багийн бусад гишүүд түүний тушаалыг гүйцэтгэж, түүний удирдлагад ажиллана.

1.4. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

БНСУ нь Ерөнхийлөгчийн засаглалтай бөгөөд төрийн байгууллагуудын удирдлагыг ихэвчлэн Ерөнхийлөгч нь томилдог онцлогтой. Улсын дээд прокурорын газар нь Ерөнхий прокурорын газартай ижил статустай байх ба Улсын дээд прокурорыг Хууль зүйн сайдын санал болгосноор Ерөнхийлөгч томилдог.

Улсын дээд прокурорын үндсэн чиг үүрэг нь:¹²⁴

- Эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаа явуулах, хяналт тавих;
- Гэм буруутай этгээдэд ял ногдуулах;
- Эрүүгийн хариуцлага, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих;
- Авлига, хээл хахуулийн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах.

БНСУ нь Авлигатай тэмцэх бие даасан байгууллагатай боловч Улсын Дээд прокурорын газрын бүтцэд авлигын эсрэг болон зохион байгуулалттай гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий тусгай хэлтэс ажилладаг. Тус хэлтэс нь Ерөнхий прокурор болон түүнд шууд харьяалагдах босоо удирдлагын тогтолцоотой ажилладаг. Прокурорын мөрдөн байцаах ажиллагааг **прокурорын цагдаа болон Тусгай мөрдөн байцаах алба** (*Special Investigation Agency*) явуулна.

Тусгай мөрдөн байцаах алба нь дүүргийн прокурорын газраас шилжүүлсэн хэрэг болон хууль тогтоомжоор өөрт харьяалуулсан гэмт хэргүүдэд тусгай мөрдөн шалгах, мөрдөн байцаах ажиллагаа явуулна. Үүнд:

1. Авлигын 5 том гэмт хэрэг - Улсын эдийн засаг, аюулгүй байдал, өрсөлдөх чадвар, ил тод байдалд хохирол учруулахуйц (авлига, зуучлах, зуучилсны төлөө төлбөр авах, хувьдаа ашиглах, завших, итгэл эвдэх) гэмт хэргийг таслан зогсоох, мөрдөн шалгах, ял шийтгэл ногдуулах;

¹²⁴https://www.iaac.mn/old/pdf/turshlaga/Korea_2015.pdf -БНСУ авлигатай тэмцэх үйл ажиллагаа, 2015 он, 8 дахь тал

2. Батлан хамгаалах үйл ажиллагаан дахь авлигын гэмт хэрэг - Үндэсний аюулгүй байдал болон батлан хамгаалах үйл ажиллагаан дахь авлигын гэмт хэрэг;

3. Үндэсний баялгийг гадагш гаргахтай холбоотой авлигын гэмт хэрэг - Улсын томоохон технологийг эзэмшиж, ашиглаж буй байгууллага, компанийн сүүлийн үеийн технологийг гадагш гаргахтай холбоотой гэмт хэргийг шуурхай илрүүлэх, мөрдөн байцаах ажиллагаа явуулах;

4. Орон нутаг дахь авлига, хүний нөөцийн томилгоотой холбоотой авлига Орон нутгийн болон төрийн байгууллагын удирдлага нь хүний нөөцийн томилгоо болон шинээр ажилд авахдаа авлига авахтай холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах;

5. Санхүүгийн болон үнэт цаастай холбоотой гэмт хэрэг - олон тооны хохирогчтой санхүүгийн гэмт хэрэг, их хэмжээний хувьцааны үнийг хуурамчаар өсгөх бууруулах замаар үйлдсэн зохион байгуулалттай гэмт хэргүүдийг мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг.

Прокурорын байгууллага нь үйл ажиллагаандаа Прокурорын тухай хууль болон Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийг дагаж мөрдөнө. Прокурорын байгууллагын тухай хуульд зааснаар шинээр хэлтэс, алба байгуулах, түүний эрх хэмжээг тогтоохтой холбоотой асуудлыг Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.

Солонгос Улсын хувьд прокурорын байгууллага нь Хууль зүйн яам, цагдаагийн байгууллага нь Дотоод хэргийн яамандаа харьяалагддаг. Хууль, хүчний байгууллагын ажилтнууд, төрийн өндөр албан тушаалтантай холбоотой гэмт хэргийг тусгайлан мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг байгууллагын талаарх мэдээлэл судалгааны явцад олдоогүй болно.

1.5. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

АНУ-д хууль сахиулах байгууллагын албан хаагчидтай холбоотой гэмт хэргийг Хууль зүйн яам (*Department of Justice*)¹²⁵ мөрдөн шалгана. Уг алба нь цагдаагийн албан хаагчид, засан хүмүүжүүлэх газрын ажилтнууд, шүүгч, прокурор болон холбооны улсын, мужийн, орон нутгийн хууль сахиулах байгууллагын албан хаагчдад холбогдох хүч хэрэглэсэн, эрх мэдэл, албан тушаалаа хэтрүүлэн ашигласан, хилсээр баривчилсан, шүүгдэж буй этгээдэд бие махбодын болон сэтгэл санааны хохирол учруулсан, санаатайгаар эмнэлгийн тусламж үзүүлэхээс зайлсхийсэн, бэлгийн дарамт үзүүлсэн, гэмт хэргийг таслан зогсоохоос зайлсхийсэн зэрэг гэмт хэргүүдийг мөрдөн шалгадаг байна. Түүнчлэн гэмт хэргийг илрүүлэх явцад саад хийсэн, хохирогч болон гэрчийг мэдүүлэг өгөхөд саад учруулсан, мэдүүлгийг хуурамчаар үйлдсэн, хэргийг нуун дарагдуулсан, баримт нотолгоог хуурамчаар үйлдсэн зэрэг хэргүүдийг мөрдөн шалгаж ял оноодог байна.¹²⁶

¹²⁵<https://www.justice.gov/crt/law-enforcement-misconduct>

¹²⁶<https://www.law.cornell.edu/uscode/text/18/242>

Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд болон төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой гэмт хэргийн мэдээллийг Хууль зүйн сайд бөгөөд Ерөнхий прокурор (цаашид Ерөнхий прокурор)-ын томилсон Тусгай төлөөлөгч (*Special Counsel*) шалгаж, мөрдлөг явуулдаг байна. (АНУ-д Ерөнхий атторней буюу Ерөнхий прокурор нь нэгэн зэрэг Хууль зүйн асуудал хариуцсан сайдын алба хашдаг)¹²⁷

АНУ-ын Хууль зүйн яамнаас 1999 онд баталсан Холбооны улсын эрх зүйн актуудын код (*Code of Federal regulations*)-ын 28 дугаар хэсгийн VI бүлгийн 600 (*28 CFR Part 600*)-д¹²⁸ **Тусгай төлөөлөгчид холбогдох** дараах асуудлуудыг зохицуулжээ. Үүнд:

- 600.1 Тусгай төлөөлөгчийг томилох үндэслэл
- 600.2 Ерөнхий прокуророос авах арга хэмжээний хувилбарууд
- 600.3 Тусгай төлөөлөгчид тавигдах шаардлага
- 600.4 Тусгай төлөөлөгчийн эрх мэдлийн хүрээ
- 600.5 Тусгай төлөөлөгчид туслах ажилтан, албан хаагчид
- 600.6 Тусгай төлөөлөгчийн бүрэн эрх
- 600.7 Тусгай төлөөлөгчийн үүрэг, хариуцлага
- 600.8 Тусгай төлөөлөгчийн мэдэгдэл болон мөрдлөгийн тайлан
- 600.9 Ерөнхий прокурорын мэдэгдэл болон тайлан

600.1 Тусгай төлөөлөгчийг томилох үндэслэл

Ерөнхий прокурор, эсхүл ерөнхий прокурор татгалзсанаар үүрэг гүйцэтгэгч томилогдсон тохиолдолд тодорхой хүн, эсхүл хэрэг дээр мөрдлөг явуулах шаардлагатай гэж үзвэл Ерөнхий прокурорын үүрэг гүйцэтгэгч дараах тохиолдолд Тусгай төлөөлөгчийг томилох эрхтэй:

(а) Ерөнхий прокурорын ажлын алба болон Хууль зүйн яамны шүүн таслах хэлтсийн ажилтнууд тухайн хүн, эсхүл тухайн асуудлыг мөрдөх, яллах ажиллагааг явуулахад ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл байдлууд үүсч болзошгүй тохиолдолд;

(б) Иргэд, олон нийтийн зүгээс тухайн хэргийг мөрдөн шалгахдаа тусгай төлөөлөгч томилохыг шаардсан тохиолдолд.

600.2 Тусгай төлөөлөгчид тавигдах шаардлага

(а) Тусгай төлөөлөгчөөр томилогдох этгээд нь хуульч мэргэжилтэй, аливаа нөлөөнд автахгүй, аль нэг талыг баримтлан шийдвэр гаргахгүй байх боломжтой, мэргэжлийн туршлага дээрээ тулгуурлан мөрдлөгийг шуурхай, нарийвчилсан байдлаар явуулах чадвартай байх ба АНУ-ын Эрүүгийн хууль болон Хууль зүйн яамны бодлогыг мөрдөн шалгах болон яллах үйл ажиллагаандаа баримталж шийдвэр гаргана. АНУ-ын Засгийн газарт ажилладаг этгээдийг тусгай төлөөлөгчөөр томилохыг хориглоно.

¹²⁷Б.Цэрэнбалтав, Б. Амарбаясгалан "Прокурорын хяналт", 2009, УБ

¹²⁸<https://www.law.cornell.edu/cfr/text/28/part-600>

(б) Тусгай төлөөлөгчөөр томилох этгээдийн талаар дэлгэрэнгүй судалгаа хийж, ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчил бий эсэхийг нарийвчлан шалгасны үндсэн дээр “итгэмжлэгдсэн ажилтан”-аар томилно.

600.4 Тусгай төлөөлөгчийн эрх мэдлийн хүрээ

Олгогдсон эрх: Ерөнхий прокурорын олгосон эрхийн хүрээнд тусгай төлөөлөгч нь үүргээ гүйцэтгэнэ. Тусгай төлөөлөгч нь ажил үүргээ гүйцэтгэхдээ тодорхой баримт нотолгоо бүхий мэдээллээр хангагдах ёстой. Тусгай төлөөлөгч нь худал мэдүүлэг өгөх, үнэн мөнийг гуйвуулах, баримт нотолгоог устгах, гэрчийг айлган сүрдүүлэх зэрэг гэмт хэргүүдийг мөрдөх, ял оноох эрхтэй.

Нэмэлт эрх: Хэргийг мөрдөх явцад тус хэргийг илрүүлэхтэй холбоотой нэмэлт ажиллагаа шаардагдсан, эсхүл шинээр мөрдлөг хийх шаардлагатай болсон тохиолдолд Ерөнхий прокурортой зөвлөлдөн шийдвэрлэнэ. Ерөнхий прокурор тусгай төлөөлөгчийн эрхийг нэмэгдүүлэх, эсхүл өөр байгууллага болон ажилтанд үүрэг өгөх зэргээр асуудлыг шийдвэрлэж болно.

Иргэний болон захиргааны эрх: Мөрдөх явцад буруутан этгээдэд захиргааны болон иргэний (эрүүгийн бус) шийтгэл ногдуулах боломжтой гэж үзвэл Ерөнхий прокурортой зөвлөлдөж шийдвэрлэнэ.

600.5 Тусгай төлөөлөгчид туслах ажилтан, албан хаагчид

Тусгай төлөөлөгч нь шаардлагатай тохиолдолд Хууль зүйн яамны ажилтнуудаас тусламж дэмжлэг авч болно. Тус яамнаас хэргийг мөрдөхөд тохиромжтой албан хаагчдын мэдээллийг тусгай төлөөлөгчид гарган өгснөөр тохирох ажилтнуудыг сонгон, тэдгээрийг удирдан, үүрэг даалгавар өгч ажиллуулна. Шаардлагатай бол тус ажилтнуудыг яамнаас гадуур ажиллуулах боломжтой.

600.6 Тусгай төлөөлөгчийн бүрэн эрх

Тусгай төлөөлөгч нь өөрт олгосон эрхийн хүрээнд АНУ-ын аль ч прокурорын адил мөрдлөг явуулах, ял оноох эрхтэй. Тусгай төлөөлөгч нь тухайн хэргийн мөрдөлт аль шатанд явж байгаа зэрэг хэрэгт холбоотой мэдээллийг Ерөнхий прокурор болон Хууль зүйн яамны ажилтнуудад мэдээлэх эсэхээ өөрөө шийднэ.

600.7 Тусгай төлөөлөгчийн үүрэг хариуцлага

(а) Тусгай төлөөлөгч нь Хууль зүйн яамны дүрэм, журам, бодлогыг баримталж ажиллана. Хэрэв тусгай төлөөлөгч өөрийн гаргасан шийдвэртээ итгэлтэй байгаа боловч тэр нь Хууль зүйн яамны дүрэм, журамд нийцэхгүй тохиолдолд нэн даруй Ерөнхий прокурортой зөвлөлдөх шаардлагатай.

(б) Тусгай төлөөлөгч нь Хууль зүйн яамны хэн нэгэн албан тушаалтны өдөр тутмын хараа хяналтан дор ажиллахгүй. Гэвч Ерөнхий прокурор нь тусгай төлөөлөгчийн хийсэн аливаа мөрдлөг болон буруутан этгээдэд ногдуулсан ялын талаар тайлбар авч болно. Хэрэв тусгай төлөөлөгчийн авсан арга хэмжээ нь Хууль зүйн яамнаас авч хэрэгжүүлдэг үйл ажиллагаатай нийцэхгүй болон шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд цаашид үргэлжлүүлэхийг хориглоно. Тус шалгалтыг явуулж, шийдвэр гаргахдаа тусгай төлөөлөгчийн цаашдын байр суурь, төлөвлөгөөг сайтар анхаарч авч үзнэ. Хэрэв Ерөнхий прокурор тусгай төлөөлөгчийн хэрэгжүүлж буй болон цаашид төлөвлөж буй үйл ажиллагаа нь шаардлагагүй болон тохиромжгүй гэж үзвэл 600.9(а)(3)-т зааснаар Конгресст мэдэгдэнэ.

(в) Тусгай төлөөлөгч болон ажлын албаны гишүүд нь Хууль зүйн яамны ажилтан, албан хаагчдын нэг адил ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн буруутай үйлдэл хийсэн тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулна. Ерөнхий прокурорын зөвшөөрлөөр Хууль зүйн яамны тодорхой хэлтэс, алба нь тухайн асуудлыг судалж, арга хэмжээ авна.

(г) Зөвхөн Ерөнхий прокурор л тусгай төлөөлөгчид шийтгэл ногдуулах болон үүрэгт ажлаас нь чөлөөлөх эрхтэй. Ерөнхий прокурор нь тусгай төлөөлөгчийг албан тушаалаа ашиглан гэмт хэрэг үйлдсэн, ажил үүргээ гүйцэтгээгүй, ашиг сонирхлын зөрчилтэй, Хууль зүйн яамны дүрэм, журмыг зөрчсөн зэрэг тохиолдлуудад үүрэгт ажлаас нь чөлөөлнө. Ерөнхий прокурор нь тусгай төлөөлөгчийг ямар шалтгааны улмаас ажлаас чөлөөлж буй тухайгаа өөрт нь бичгээр мэдэгдэнэ.

600.8 Тусгай төлөөлөгчийн ажлын тайлан

(а) Төсөв

- (1) Хууль зүйн яамнаас тусгай төлөөлөгчийг үүрэгт ажлаа гүйцэтгэх бүхий л нөөц бололцоогоор хангана. Томилогдсоноосоо хойш 60 хоногийн дотор тусгай төлөөлөгч нь Хууль зүйн яамны Зохион байгуулалтын хэлтэстэй хамтран төсвийн санал боловсруулж, Ерөнхий прокурорт хянуулахаар өгнө. Тухайн санал дээр үндэслэн Ерөнхий прокурор нь тусгай төлөөлөгчийн үйл ажиллагааны төсвийг боловсруулна. Төсөвт мэргэшил, дадлага бүхий албан хаагчийг авч ажиллуулах зардлыг багтаасан байна.
- (2) Санхүүгийн жил эхлэхээс 90 хоногийн өмнө тусгай төлөөлөгч нь Ерөнхий прокурорт хэргийн мөрдлөгийн үйл явцыг мэдээлж, дараа жилийн төсвийн саналаа танилцуулна. Ерөнхий прокурор нь мөрдөх үйл ажиллагааг үргэлжлүүлэх шаардлагатай гэж үзвэл ирэх жилийн төсөвт тусгана.

(б) Онц чухал үйл явдлуудын талаар мэдээлэх

Тусгай төлөөлөгч нь Хууль зүйн яамны дүрэм, журамд заасны дагуу мөрдлөгийн явцад бий болсон гэнэтийн үйл явдлын талаар Ерөнхий прокурорт мэдээлэх шаардлагатай.

(в) Гэмт хэргийг хаах

Тусгай төлөөлөгч нь мөрдөн шалгах үйл явц дууссаны дараа гэмт этгээдэд ногдуулсан ял, эсхүл гэм буруугүйг нотолсон нотолгоог Ерөнхий прокурорт танилцуулна.

600.9 Ерөнхий прокурорын тайлан

(а) Ерөнхий прокурор нь доорх нөхцөлүүдэд Конгрессын хоёр танхимын Хууль зүйн хорооны дарга нарт мэдэгдэл хийнэ. Үүнд:

- (1) Тусгай төлөөлөгчийг томилоход;
- (2) Тусгай төлөөлөгчийг чөлөөлөхөд;
- (3) Тусгай төлөөлөгчийн авсан арга хэмжээ нь Хууль зүйн яамны дүрэм, журмыг зөрчсөн, тухайн арга хэмжээг авах шаардлагагүй байсан, эсхүл тохиромжгүй арга хэмжээ авсан гэж үзэн мөрдлөгийг үргэлжлүүлэхийг хориглосон тохиолдолд.

(б) Тусгай төлөөлөгчийн мөрдсөн болон ял ногдуулсан аливаа хэргийг Хууль зүйн яамны дүрэм, журамд заасны дагуу Ерөнхий прокурор олон нийтэд мэдээлэх эсэхийг шийдвэрлэнэ.

1.6. УКРАИН УЛС

Украин улсын 2012 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль¹²⁹ (ЭХХШТХ)-д зааснаар:

- Дотоод хэргийн асуудал эрхэлсэн байгууллага;
- Тагнуулын байгууллага;
- Татварын хууль тогтоомжийн дагуу хяналт, шалгалт явуулах эрх бүхий төрийн байгууллага;
- Авлигатай тэмцэх газар,
- Улсын мөрдөн байцаах газар нь мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиг үүргийг гүйцэтгэдэг байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлд зааснаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын мөрдөгчид нь дараах бүрэн эрхтэй байхаар хуульчилжээ. Үүнд:

- ЭХХШТХ-д заасан үндэслэлээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах;
- ЭХХШТХ-д заасан мөрдөн байцаалтын эрэн сурвалжлах ажиллагаа явуулах;

¹²⁹Criminal procedure code of Ukraine, <https://rm.coe.int/16802f6016>

- Эрэн сурвалжлах болон нууц мөрдөн шалгах ажиллагаа гүйцэтгэхийг холбогдох байгууллагад даалгах;
- Хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу аудитын болон холбогдох шалгалт явуулах шийдвэр гаргах;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай холбогдох зөвшөөрлийг шүүх, прокуророос авах, танилцуулах;
- Прокурортой зөвшилцөн сэжигтнээр тооцох;
- Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд үндэслэн яллах дүгнэлт үйлдэх, эмнэлгийн болон боловсролын албадлагын арга хэмжээ хэрэглэх талаар прокурорт санал гаргах, зөвшөөрөл авах;
- Мөрдөн шалгах ажиллагааг зогсоох зэрэг хуульд заасан үндэслэлээр мөрдөн шалгах ажиллагааны шийдвэрүүд гаргах;
- ЭХХШТХ-иар олгосон бусад бүрэн эрх.

Тус хуулийн 216 дугаар зүйлд мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагуудын хэргийн харьяаллыг тогтоож өгсөн байна. Үүнд:

- Тагнуулын байгууллага нь төрийн эрх мэдлийг хууль бусаар авах зэрэг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 1 дүгээр бүлэгт заасан үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд, хууль бусаар хил давуулах болон төрийн нууц, хилийн халдашгүй байдал, цэрэг татлага, дайчилгаатай холбогдох гэмт хэргүүд, энх тайван, хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүдэд;
- Татварын холбогдох байгууллага нь татвар, албан журмын даатгалаас зайлсхийх, зориудаар дампууруулах, төлбөрийн чадваргүй болгох, хууль бус үйлдвэрлэл, худалдааны гэмт хэргүүдэд болон дээрх гэмт хэргүүдийг мөрдөн шалгах эрх бүхий этгээдээс үйлдсэн тохиолдолд тус гэмт хэргүүдэд;
- Улсын мөрдөн байцаах газар(УМБГ) нь Төрийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан албан тушаал ерөнхийлөгч, парламентын гишүүд, засгийн газрын гишүүд, үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, сонгуулийн төв хорооны гишүүд, засгийн газрын гишүүд, төв банкны ерөнхийлөгч, шүүгч болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудын үйлдсэн гэмт хэрэг, мөн авлигатай тэмцэх газрын албан хаагчдын үйлдсэн Эрүүгийн хуулийн худал мэдүүлэг өгөх, худал мэдүүлэг өгүүлэхээр албадах, мөрдөн шалгах ажиллагааны нууц задруулах, гэмт хэргийг үл мэдээлэх гэмт хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагааг явуулна.
- Дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын мөрдөгч нар нь дээр дурдсанаас бусад гэмт хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагааг явуулна.
- УМБГ-аас мөрдөн шалгах ажиллагаа явуулах хуулийн зохицуулалтыг 2014 оны 10 дугаар сарын 14-ний өдөр хуульд нэмэлт өөрчлөлт оруулан шийдвэрлэсэн бөгөөд мөн тус өдөр Прокурорын байгууллагын тухай хуулийг шинэчлэн баталж¹³⁰, уг хуулиар Үндсэн хуулиар

¹³⁰law on the Public Prosecutor's Office, The Law of Ukraine, [https://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=C-DL-REF\(2013\)041-e](https://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=C-DL-REF(2013)041-e)

тогтоосон чиг үүрэгт харшлах тул прокурорын байгууллага нь Үндсэн хуулиар тогтоосон чиг үүрэгт хамаарахгүй чиг үүргийг гүйцэтгэхгүй гэж тухайлан зааж, хуучин прокурорын байгууллагаас мөрдөн шалгах ажиллагаа явуулж байсныг зогсоон, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дотор Улсын мөрдөн байцаах газрыг байгуулж, тус байгууллагыг чиг үүргээ гүйцэтгэж эхлэх хүртэл прокурорын байгууллага мөрдөн шалгах ажиллагааг явуулж байхаар тогтоосон байна.

Украины парламентаас 2015 оны 11 сарын 12-ны өдөр Улсын мөрдөн байцаах газрын тухай хууль¹³¹-ийг баталж, 2016 оны 3 дугаар сарын 1-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн байна.

Улсын мөрдөн байцаах газар нь Засгийн газрын дэргэдэх төв байгууллага гэсэн эрх зүйн байдалтайгаар ажилладаг ба тус байгууллагаас явуулах мөрдөн шалгах ажиллагаанд Прокурорын байгууллага хяналт тавьж ажилладаг байна. УМБГ-ын тухай хуулийн 5 дугаар зүйлд тус байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөн шалгах гэж томъёолоод харьяалан шалгах субъектийг ЭХХШТХ-д зааснаар тодорхойлсон байна.

УМБГ-ын тухай хуулийн 6 дугаар зүйлд Мөрдөн байцаах албаны бүрэн эрхийг дараах байдлаар заасан байна. Үүнд:

- Гэмт хэрэгтэй тэмцэх;
- Мөрдөн байцаах албаны эрх мэдэлд хамаарах гэмт хэргийг таслан зогсоох;
- Тодорхой төрлийн гэмт хэргийн мөрдөн байцаах арга зүйг боловсруулж батлуулах;
- Хуульд заасны дагуу гэмт хэргийн үр дүнд олж авсан эд хөрөнгийг хураан авах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авах;
- Холбогдох чиглэлээр мэргэжилтнүүдийг сургах, мэргэжил дээшлүүлэх, давтан сургах;
- Гадаад улсын эрх бүхий байгууллагаас хүлээн авсан хууль зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэх;
- Украин Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу цагдаа болон бусад холбогдох байгууллагатай хамтран ажиллах;
- Энэ хуульд заасан журмын дагуу өөрийн үйл ажиллагааны талаар тайлан гаргаж, ажлын үр дүнг олон нийтэд мэдээлэх;
- Хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Улсын мөрдөн байцаах албаны тогтолцоо нь төв аппарат, нутаг дэвсгэрийн нэгж дэх салбар, тусгай нэгж, боловсрол, судалгааны байгууллагаас бүрдэнэ. Улсын мөрдөн байцаах албаны үйл ажиллагаа, зохион байгуулалтын бүтцийг мөрдөн байцаах албаны дарга нь Засгийн газартай зөвшилцөж батлахаар заасан байна.

¹³¹The Law of Ukraine "On the State Bureau of Investigation", <https://zakon3.rada.gov.ua/laws/show/794-19>

УМБГ-ын даргыг Ерөнхий сайдын санал болгосноор Украин Улсын Ерөнхийлөгч 5 жилийн хугацаагаар томилох ба улируулан томилохыг хориглоно. Улсын мөрдөн байцаах газрын дарга, түүний орлогч нарт тавигдах шаардлагад:

- 1) 35-аас доошгүй настай;
- 2) хууль зүйн өндөр боловсролтой;
- 3) хамгийн багадаа арван жил хуулийн байгууллагад ажилласан байх;
- 4) удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- 5) улс төрийн намын гишүүнчлэлгүй байх;
- 6) өндөр ёс суртахуунтай, нэр хүндтэй;
- 7) эрүүл мэндийн хувьд албан үүргээ биелүүлэх бүрэн чадвартай байх.

2016 оны 3 дугаар сард Засгийн газраас Ерөнхийлөгч, Парламент, Засгийн газрыг төлөөлсөн гурав гурван гишүүн буюу нийт 9 гишүүн бүхий УМБГ-ын албан хаагчдыг сонгон шалгаруулах хороог байгуулсан бөгөөд улмаар 2017 онд УМБГ-ын даргыг томилсон. УМБГ-ын дарга нь тус хорооноос нэр дэвшүүлсэн дэд дарга болон бусад мөрдөгч нарыг томилно.

Улсын мөрдөн байцаах албаны төв оффис, нутаг дэвсгэрийн нэгжийн тоонд хамаарах нийт ажилтны тоо дээд тал нь 1500 хүн байхаар хуульд заасан байна. УМБГ нь 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар нийт 295 мөрдөгч ажиллаж байгаагаас төв оффист 102 мөрдөгч, орон нутаг дахь салбарт 193 мөрдөгч ажиллаж байна.

ХОЁР. МОНГОЛ УЛС

2.1 Монгол Улсын мөрдөн байцаах албаны үүсэл, хөгжил түүний өөрчлөлт, шинэчлэл

Дотоод явдлын яамны сайдын 1946 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 504 тоот тушаалаар Цагдан сэргийлэх газрын гүйцэтгэх 1 дүгээр хэлтсийн харьяанд "... ард иргэдийн өргөдөл гомдлыг шалган барагдуулах, мөрдөн байцаалт явуулж байх үүрэгтэй тусгай группийг байгуулснаар Мөрдөн байцаах албаны үндэс суурь тавигджээ".¹³²

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1962 оны 144 дүгээр зарлиг, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн мөн оны 313 дугаар тогтоолоор Цагдан сэргийлэх ерөнхий газрын системд ажиллаж байсан Мөрдөн байцаах аппаратыг татан буулгаж, 1962 оны 07 дугаар сарын 01-нээс Прокурорын байгууллагад мөрдөн байцаах албыг төвлөрүүлэн, Улаанбаатар хотын прокурорын газарт Мөрдөн байцаах газар, аймгийн прокурорын газарт Мөрдөн байцаах группийг ажиллуулахаар шийдвэрлэжээ.¹³³

Мөрдөн байцаах ажлын удирдлага зохион байгуулалт оновчтой биш, хэргийн илрүүлэлт хангалтгүй шалтгаанаар МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны 1964 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 218 дугаар тогтоолоор мөрдөн байцаах ажлыг Цагдан сэргийлэх байгууллагад шилжүүлж, НАХЯ-ны сайдын 1964 оны 511 дугаар тушаалаар Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын харьяа Мөрдөн байцаах газрыг байгуулсан.

Прокурорын байгууллагын үйл ажиллагааг Монгол Улсын үндсэн хуульд нийцүүлэн зохицуулах зорилгоор Улсын Бага Хурлын 1992 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 36 дугаар тогтоолоор Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг орон тоо, төсөв, эд хөрөнгийн хамт Цагдаагийн ерөнхий газарт шилжүүлж байжээ.¹³⁴

Энэ үеэс Мөрдөн байцаах албаны үйл ажиллагаа төвлөрч, материаллаг бааз бэхжиж, дээд боловсролтой, хуульч, эрх зүйч мэргэжилтэй боловсон хүчнээр бүрэн хангагдаж, төвдөө төрөлжсөн 8 хэлтэс, аймаг, дүүргийн 31 тасагтай болсон байна.¹³⁵

Эрх зүйн тогтолцооны шинэчлэл, нийгмийн харилцааны өөрчлөлттэй холбоотойгоор "Прокурорын байгууллагын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2002 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 47 дугаар тогтоол батлагдсантай холбоотойгоор Засгийн газрын 2002 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 179 дүгээр тогтоолын дагуу Мөрдөн байцаах албаны мөрдөн байцаагчдыг орон тоо, төсөв, эд хөрөнгийн хамт

¹³²mbg.police.gov.mn/news/content/id/718/type/119/menuid/86 /Мөрдөн байцаах албаны товч түүх/

¹³³polita.blogmn.net/77730/ulsyn-murdun-baicaah-gazar.html /Улсын Мөрдөн байцаах газар/

¹³⁴dardas.mn/news/view/7830 /Авилгатай тэмцэх газарт Мөрдөн байцаах албыг нэгтгэснээс хойш,/

¹³⁵Монгол Улсын Их Хурал "Прокурорын байгууллагын тухай" хуулийн хувийн хэрэг. /Д-5; ХН-794/

цагдаагийн байгууллагаас Улсын ерөнхий прокурорын мэдэлд шилжүүлэн, Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Мөрдөн байцаах алба байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ.¹³⁶

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай мөн өдрийн хуулиар Прокурорын байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйл / Улсын прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба, 45 дугаар зүйл мөрдөн байцаах албаны мөрдөн байцаагч/-ийг тус тус хүчингүй болсноор Прокурорын байгууллагын дэргэдэх мөрдөн байцаах алба татан буугдаж, тагнуул, цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн албан тушаал, авлигын гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байсан харьяалал нь Авлигатай тэмцэх газарт шилжжээ.¹³⁷

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

¹³⁶ Монгол Улсын Их Хурал “Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн хувийн хэрэг /Д-8; ХН-839/

¹³⁷ <https://www.iaac.mn/page/54?menu=146&lang=en>

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

АРМЕН УЛС:

- Закон Республики Армения “О Специальной Следственной Службе” <http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=3124&lang=rus>
- Устав государственного управленческого учреждения “Аппарат Специальной Следственной Службы Республики Армения” <http://www.ccc.am/ru/1428578692/55>
- Специальная следственная служба Республики Армения <http://www.ccc.am/ru/>

ОХУ:

- “Уголовно-процессуальный кодекс Российской Федерации” от 18.12.2001 N 174-ФЗ
- Положение о Следственном департаменте МВД РФ. Утвержден приказом МВД России от 1 июля 2011 г. N 780 “Об утверждении положения о Следственном департаменте Министерства внутренних дел РФ”. Эх сурвалж: ДХЯ-ны цахим хуудас: <https://sledcom.ru> - 2019.04.04.
- Конституция РФ (12.12.1993). Эх сурвалж: <http://www.constitution.ru>
- Закон О Следственном комитете РФ от 28.12.2010 N 403-ФЗ. Эх сурвалж: https://sledcom.ru/documents/Pravovaja_informacija
- Уголовно-процессуальный кодекс РФ от 18.12.2001 г. № 174-ФЗ. Эх сурвалж: <http://ivo.garant.ru>
- Уголовный кодекс РФ от 13.06.1996 N 63-ФЗ. Эх сурвалж: <http://www.consultant.ru>
- Указ Президента РФ No 1182 от 27.09.2010 “Вопросы Следственного комитета РФ”.
- Эх сурвалж: https://sledcom.ru/documents/Pravovaja_informacija - 2019.04.04.
- Указ Президента РФ No 14.01.2011 “Вопросы деятельности Следственного комитета РФ”.
- Эх сурвалж: https://sledcom.ru/documents/Pravovaja_informacija - 2019.04.04.
- МБХ-ны түүх. Эх сурвалж: МБХ-ны цахим хуудас: <https://sledcom.ru> - 2019.04.04.
- МБХ-ны түүх. Эх сурвалж: МБХ-ны цахим хуудас: <https://sledcom.ru> - 2019.04.04.
- ФЗ О Следственном комитете РФ от 28.12.2010 г. № 403-ФЗ.
- Указ Президента РФ от 14.01.2011 № 38 “Вопросы деятельности СК РФ”.

МОНТЕНЕГРО УЛС:

- law on special public prosecutor's office of Montenegro [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2015\)012-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2015)012-e)
- <https://www.tuzilastvocg.me/index.php/en/special-state-prosecutor-s-office>

ӨМНӨД СОЛОНГОС УЛС:

- https://www.unafei.or.jp/publications/pdf/RS_No53/No53_13VE_Soo.pdf
- <http://www.spo.go.kr/site/eng/main.do>
- <http://www.law.go.kr/법령/검찰청법/-Прокурорын байгууллагын хууль /солонгос хэлээр/>

АНУ:

- <https://fas.org/sdp/crs/misc/R44857.pdf>
- <https://www.law.cornell.edu/cfr/text/28/part-600>
- <https://www.justice.gov/crt/law-enforcement-misconduct>
- <https://www.justice.gov/crt/addressing-police-misconduct-laws-enforced-department-justice>
- <https://www.law.cornell.edu/uscode/text/18/242>
- <https://www.law.cornell.edu/uscode/text/34/12601>
- <https://www.justice.gov/opa/press-release/file/967231/download>

УКРАИН УЛС:

- [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2014\)047-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2014)047-e)
- <https://www.unian.info/politics/2252799-ukraines-state-bureau-of-investigation-completely-replaces-pgo.html>
- <https://www.kyivpost.com/ukraine-politics/state-bureau-of-investigation-to-officially-commence-work-on-nov-27.html>
- <https://antac.org.ua/en/analytics/who-will-lead-the-state-bureau-of-investigations/>
- Criminal procedure code of Ukraine, <https://rm.coe.int/16802f6016>
- <https://zakon.rada.gov.ua/laws/show/en/794-19>
- law on the Public Prosecutor's Office, The Law of Ukraine, [https://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=CDL-REF\(2013\)041-e](https://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=CDL-REF(2013)041-e)
- The Law of Ukraine “On the State Bureau of Investigation”, <https://zakon3.rada.gov.ua/laws/show/794-19>

МОНГОЛ УЛС:

- mbg.police.gov.mn/news/content/id/718/type/119/menuid/86 /Мөрдөн байцаах албаны товч түүх/
- lolita.blogmn.net/77730/ulsyn-murdun-baicaah-gazar.html /Улсын Мөрдөн байцаах газар/
- lolita.blogmn.net/77730/ulsyn-murdun-baicaah-gazar.html /Улсын Мөрдөн байцаах газар/
- www.legalinstitute.mn/